

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр Утас: 261729 Цахим хаяг: oyuntuguldurg@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	17
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа	17
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	18
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	20
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	20
3.4.1 Мөнгөн хөрөнгө	21
3.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	23
3.4.3 Авлага	24
3.4.4 Урьдчилгаа	25
3.4.5 Бараа материал	26
3.4.6 Нөөцийн бараа	27
3.4.7 Бусад эргэлтийн хөрөнгө	28
3.4.8 Үндсэн хөрөнгө	28
3.4.9 Өр төлбөр	30
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо	31
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	32
3.5.1 Төсвийн төлөвлөлт	32
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	32
3.5.3 Нэмэлт төсөв	33
3.5.4 Судалгааны үр дүн	33
3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	34
4. АУДИТЫН ТАЙЛАН	38
4.1 Ерөнхий зүйл	38
4.2 Материаллаг байдал	38
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	38
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	39
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	40
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	41
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	51
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	52
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	53
5.1 Харьяа байгууллагууд	53
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит	53
5.2.1 Аудитаар илэрсэн зөрчил	53
Албан шаардлага	54
Зөвлөмж	57
5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагуудын аудитаар:	59
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	69

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БС	Боловсролын сайд
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МБСБ	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн шалтгаалах өвчин
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль



БОЛОВСРОЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1153
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 261,046.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 152,622.0 сая төгрөгийн материаллаг хэмжээний зөрчил илэрсэн;
- Боловсролын салбарын 2012-2025 оны хооронд хэрэгжиж дуусах 99,920.3 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай, он дамжсан, хэрэгжилт хангалтгүй, хөрөнгийн эх үүсвэргүй болсон;
- Өмнөх оноос ажиллагсадтай холбоотой авлага 1,016.9 сая төгрөгөөр, өглөг 2,960.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Боловсролын салбарт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас буцалтгүй тусламжаар 7 сургууль, 1 цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг 2019 оноос 3 үе

Z:\Yawsan_Bichig\2026\0424 SAG-38.Docx

1526090668

шаттайгаар хэрэгжүүлж, 2020-2021 онд ашиглалтад орсон боловч 3,374.7 сая төгрөгийн 3 сургуулийн барилгын улсын комиссын акт эцэслэн баталгаажуулж, эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэгдээгүй;

- Сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд төрийн өмчийн барилга, байгууламжийн сул, зай талбайг судлан, дотоод нөөц бололцоогоо ашиглалгүйгээр оффис түрээслэн тайлант онд 4 байгууллага 1,152.3 сая төгрөгийг үрэлгэн зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36, 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, 2024 оны 139 дүгээр тогтоол, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1, 208 дугаар зүйлийн 208.1, 211 дүгээр зүйлийн 211.1 дэх заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын сайдын сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай 2025 оны А/404 дүгээр тушаалаар сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг шинэчлэн баталж, Хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжиж, танин мэдэхүй, нийгэмшлийн суурь болон ерөнхий чадамжийг эзэмшүүлж, сургуульд бэлтгэх зорилгыг дэвшүүлэн 2025-2026 оны хичээлийн жилээс өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгт хэрэгжүүлж эхэлсэн байна.

Тайлант онд Монгол хэл бичгийн шалгалтыг Х-ХII ангийн 84,969 суралцагчаас, элсэлтийн ерөнхий шалгалтыг 10 төрлийн хичээлээр давхардсан тоогоор 143,318 шалгуулагчаас авч, монгол хэл бичгийн шалгалтад 70,410 суралцагч, элсэлтийн ерөнхий шалгалтад 103,214 шалгуулагч босго оноо давсан байна.

Боловсролын сайдын 2025 оны А/574 дүгээр тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг тогтоох ажлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран зохион байгуулахыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд даалгаж, үйл ажиллагаа зохион байгуулах зардал 1,860.0 сая төгрөгийг баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч хууль, тогтоомж, холбогдох журмын шинэчлэл, өөрчлөлттэй нийцүүлээгүй, салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй байна.

Тухайлбал, дижитал сурах бичиг, цахим систем, олон улсын хөтөлбөрүүдийн бүртгэл, түрээсийн номын сангийн бүртгэл, сурах бичиг хэвлүүлэх, орлого авах, байгууллагуудад хуваарилж тараах, хяналт хэрэгжүүлэх зэрэгт бүртгэлээр баримтлах бодлого, зохицуулалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг салбарын хамтын хэлэлцээр, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан төсөвтөө багтаан нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн байна.

Боловсролын үнэлгээний төв нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж, 1,725 байгууллагын 36,853 багш, 1,634,933 суралцагчийг түүвэрт хамруулан үнэлж, I-V түвшинд дүгнэсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,120,324,350.0	3,235,155,820.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	589,085,189.9	346,013,334.4
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	58,225.8	1,319,762.9
33	АВЛАГА	347,734,842.1	352,178,515.2
34	УРЬДЧИЛГАА	174,330,717.4	233,357,043.6
35	БАРАА МАТЕРИАЛ	261,286,903.8	283,725,658.6
36	НӨӨЦИЙН БАРАА	-	49,345.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,747,828,471.1	2,018,512,160.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,391,946,436.8	5,973,952,520.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,391,946,436.8	5,973,952,520.2
39200	Биет хөрөнгө	4,316,960,608.7	4,893,021,582.5
39300	Биет бус хөрөнгө	1,074,985,828.1	1,080,930,937.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,512,270,786.8	9,209,108,340.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	161,236,893.5	123,193,016.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	161,199,616.5	123,160,710.0
41300	Өглөг	98,403,175.1	59,354,716.4
41400	Урьдчилж орсон орлого	62,796,441.4	63,805,993.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,276.9	32,306.7
42200	Урт хугацаат зээл	37,276.9	32,306.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,351,033,893.3	9,085,915,324.0
51	Засгийн газрын хувь оролцоо	8,351,033,893.3	9,085,915,324.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,102,747,186.0	1,267,381,842.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	765,568,561.6	784,691,073.6
51200	Хуримтлагдсан үр дүн	5,309,531,629.2	5,856,129,205.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,173,186,516.5	1,177,713,201.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,512,270,786.8	9,209,108,340.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,021,845,030.7	5,369,670,768.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	99,906.9	716,975.6
110	Орлогын албан татвар	99,906.9	716,975.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	99,906.9	716,975.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	977,488,744.6	5,368,953,792.6
120	Нийтлэг татварын бус орлого	947,835,136.2	1,421,777,751.0
122	Тусламжийн орлого	29,653,608.4	3,946,864,788.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,044,256,379.2	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,939,878,314.3	4,591,715,468.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,939,706,923.1	4,480,031,417.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,495,486,212.6	4,055,762,696.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,371,335,773.8	2,891,470,687.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	292,057,932.7	355,329,902.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,259,677.7	49,372,785.8
2104	Хангамж, бараа материалын зардал	134,096,260.0	54,744,428.6
2105	Нормативт зардал	139,802,985.5	160,986,216.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,173,112.5	15,025,001.4
2107	Томилолт, зочны зардал	4,389,664.4	3,877,886.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	86,616,637.3	91,214,650.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	410,754,168.7	433,741,138.4
211	ХҮҮ	470,122.4	230,838.1
212	ТАТААС	75,000.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	443,675,588.0	424,037,883.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	171,391.2	111,684,051.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,081,966,716.4	777,955,299.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,321,240.4	2,240,864.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	150,948,978.7	45,879,618.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(149,627,738.3)	(43,638,754.4)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	932,338,978.1	734,316,545.2

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,375,727,981.6	-	7,375,727,981.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	48,329,090.0	-	48,329,090.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,424,057,071.6	-	7,424,057,071.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,147,271.1)	-	(10,147,271.1)
7	Өмчид гарсан өөрчлөлт	4,785,114.8	-	4,785,114.8
9	Тайлант үеийн үр дүн	932,338,978.1	-	932,338,978.1
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,351,033,893.3	-	8,351,033,893.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,593,185.4)	-	(4,593,185.4)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,346,440,707.9	-	8,346,440,707.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	4,055,601.7	-	4,055,601.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,250,975.1	-	1,250,975.1
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	355.3	-	355.3
17	Өмчид гарсан өөрчлөлт	(148,861.1)	-	(148,861.1)
19	Тайлант үеийн үр дүн	734,316,545.2	-	734,316,545.2
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,085,915,324.0	-	9,085,915,324.0

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,544,205,789.9	4,508,445,565.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	487,918,327.5	4,508,445,565.1
120	Нийтлэг татварын бус орлого	487,810,443.5	565,453,662.3
122	Тусламжийн орлого	107,884.0	3,942,991,902.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,056,287,462.4	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,676,193,526.3	4,296,688,997.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,676,193,526.3	4,296,688,997.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,170,694,298.4	3,777,915,131.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,368,292,907.6	2,888,075,957.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,359,248.8	356,759,841.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,768,770.5	54,976,977.4
2104	Хангамж, бараа материалын зардал	10,335,621.3	11,688,224.2
2105	Нормативт зардал	131,724,822.7	147,074,293.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,712,836.2	13,328,090.4
2107	Томилолт, зочны зардал	3,993,082.6	3,277,253.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,192,644.4	112,983,995.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,314,364.4	189,750,498.6
211	ХҮҮ	435,427.0	241,983.3
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	505,063,800.9	518,531,883.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	868,012,263.6	211,756,567.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	684,301,362.0	458,115,607.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	684,301,362.0	458,115,607.7
2200	Дотоод эх үүсвэрээр	684,301,362.0	458,115,607.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(684,301,362.0)	(458,115,607.7)
14	Бусад эх үүсвэр	5,813,157.1	21,543,519.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	13,487,783.0	14,647,228.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	9,137,565.7	3,609,105.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(16,812,191.7)	3,287,184.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	166,898,709.9	(243,071,855.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	422,186,480.0	589,085,189.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	589,085,189.9	346,013,334.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛ СЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,259,894,799,200.00	3,919,420,329,508.99	340,474,469,691.01	92.0
12	Татварын бус орлого	4,259,894,799,200.00	3,919,420,329,508.99	340,474,469,691.01	92.0
120	Нийтлэг татварын бус орлого	6,534,825,300.00	7,374,168,026.85	(839,342,726.85)	112.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	6,477,325,300.00	7,255,689,194.85	(778,363,894.85)	112.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	57,500,000.00	118,478,832.00	(60,978,832.00)	206.1
122	Тусламжийн орлого	4,253,359,973,900.00	3,912,046,161,482.14	341,313,812,417.86	92.0
122005	Төсвөөс санхүүжих	4,253,359,973,900.00	3,912,046,161,482.14	341,313,812,417.86	92.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,263,498,999,200.00	3,918,347,135,989.87	345,151,863,210.13	91.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,819,213,412,100.00	3,578,476,071,418.46	240,737,340,681.54	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,124,824,331,100.00	2,958,988,625,617.13	165,835,705,482.87	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,300,374,828,300.00	2,250,710,613,309.89	49,664,214,990.11	97.8
210101	Үндсэн цалин	1,428,696,458,300.00	2,153,035,060,346.41	(724,338,602,046.41)	150.7
210102	Нэмэгдэл	800,733,705,100.00	86,630,595,704.86	714,103,109,395.14	10.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,193,211,600.00	7,328,115,712.19	7,865,095,887.81	48.2
210104	Урамшуулал	55,113,682,100.00	3,706,693,817.43	51,406,988,282.57	6.7
210105	Гэрээт ажлын хөлс	637,771,200.00	10,147,729.00	627,623,471.00	1.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	292,201,696,900.00	291,034,170,882.20	1,167,526,017.80	99.6
210201	Тэтгэврийн даатгал	206,597,280,200.00	280,864,657,438.93	(74,267,377,238.93)	135.9
210202	Тэтгэмжийн даатгал	23,383,439,900.00	2,556,758,176.95	20,826,681,723.05	10.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,691,890,400.00	1,294,308,277.03	10,397,582,122.97	11.1
210204	Ажилгүйдлийн даатгал	10,294,895,000.00	1,258,262,870.55	9,036,632,129.45	12.2
210205	Эрүүл мэндийн даатгал	40,234,191,400.00	5,060,184,118.74	35,174,007,281.26	12.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,735,568,700.00	26,750,610,453.50	1,984,958,246.50	93.1
210301	Гэрэл, цахилгаан	789,435,300.00	716,216,021.76	73,219,278.24	90.7
210302	Түлш, халаалт	1,655,069,300.00	1,549,248,137.85	105,821,162.15	93.6

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	270,225,200.00	240,330,199.23	29,895,000.77	88.9
210304	Байрны түрээс	26,020,838,900.00	24,244,816,094.66	1,776,022,805.34	93.2
2104	Хангамж, бараа материалын зардал	918,266,800.00	681,471,283.36	236,795,516.64	74.2
210401	Бичиг хэрэг	175,843,900.00	164,432,216.74	11,411,683.26	93.5
210402	Тээвэр, шатахуун	109,839,300.00	103,199,726.20	6,639,573.80	94.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	302,095,200.00	200,001,860.96	102,093,339.04	66.2
210404	Ном, хэвлэл	15,947,800.00	15,122,400.00	825,400.00	94.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,044,900.00	15,677,470.00	34,367,430.00	31.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	264,495,700.00	183,037,609.46	81,458,090.54	69.2
2105	Нормативт зардал	189,671,528,700.00	118,136,777,674.00	71,534,751,026.00	62.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,732,600.00	6,476,851.00	5,255,749.00	55.2
210502	Хоол, хүнс	189,653,525,000.00	118,124,037,323.00	71,529,487,677.00	62.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,271,100.00	6,263,500.00	7,600.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	653,839,800.00	568,465,482.00	85,374,318.00	86.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	325,738,900.00	300,523,010.00	25,215,890.00	92.3
210602	Тавилга	46,669,300.00	27,099,400.00	19,569,900.00	58.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,502,300.00	193,000.00	6,309,300.00	3.0
210604	Урсгал засвар	274,929,300.00	240,650,072.00	34,279,228.00	87.5
2107	Томилолт, зочны зардал	163,396,500.00	163,359,458.00	37,042.00	100.0
210702	Дотоод албан томилолт	163,396,500.00	163,359,458.00	37,042.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,721,872,300.00	135,923,081,484.00	22,798,790,816.00	85.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,009,554,300.00	135,469,350,901.80	22,540,203,398.20	85.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	61,677,600.00	36,170,900.00	25,506,700.00	58.6
210803	Даатгалын үйлчилгээ	13,064,900.00	3,410,121.28	9,654,778.72	26.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,286,300.00	4,120,223.50	4,166,076.50	49.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,691,100.00	477,400.00	3,213,700.00	12.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	585,940,400.00	393,306,304.42	192,634,095.58	67.1

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	13,922,300.00	5,749,224.00	8,173,076.00	41.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,787,100.00	186,030.00	2,601,070.00	6.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,948,300.00	10,310,379.00	12,637,921.00	44.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,383,333,100.00	135,020,075,590.18	18,363,257,509.82	88.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	151,965,119,300.00	134,103,575,540.02	17,861,543,759.98	88.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,418,213,800.00	916,500,050.16	501,713,749.84	64.6
212	ТАТААС	2,116,628,200.00	2,116,628,100.00	100.00	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,116,628,200.00	2,116,628,100.00	100.00	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,116,628,200.00	2,116,628,100.00	100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	692,272,452,800.00	617,370,817,701.33	74,901,635,098.67	89.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	242,664,088,700.00	232,040,359,217.45	10,623,729,482.55	95.6
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	242,664,088,700.00	232,040,359,217.45	10,623,729,482.55	95.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	449,608,364,100.00	385,330,458,483.88	64,277,905,616.12	85.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	312,558,851,300.00	250,073,152,348.83	62,485,698,951.17	80.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,970,224,500.00	55,847,369,931.05	1,122,854,568.95	98.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	79,949,078,200.00	79,292,845,908.00	656,232,292.00	99.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	130,210,100.00	117,090,296.00	13,119,804.00	89.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	446,352,890,200.00	341,596,729,484.69	104,756,160,715.31	76.5
220001	Барилга байгууламж	415,429,790,200.00	313,188,406,147.09	102,241,384,052.91	75.4
221001	Их засвар	249,500,000.00	-	249,500,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	30,673,600,000.00	28,408,323,337.60	2,265,276,662.40	92.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(2,067,303,100.00)	(1,725,664,913.28)	(341,638,186.72)	83.5
230001	Эргэж төлөгдөх зээл	(2,067,303,100.00)	(1,725,664,913.28)	(341,638,186.72)	83.5

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	ТЭНЦВЭРЖҮҮЛ СЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,604,200,000.00)	1,073,193,519.12	(4,677,393,519.12)	(29.8)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,604,200,000.00	(1,073,193,519.12)	4,677,393,519.12	(29.8)
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1865	1865	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	20,489,939,836.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	20,489,939,836.63
122	Тусламжийн орлого	-	20,489,939,836.63
1221	Хандив тусламж /дотоод/	-	20,489,939,836.63
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	20,489,939,836.63
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,386,201,955.84
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,327,231,919.56
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,839,048,006.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,937,457,955.23
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	18,886,749,506.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	18,886,749,506.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	14,533,809,644.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,812,194,236.96
210101	Үндсэн цалин	-	671,100,473.19
210102	Нэмэгдэл	-	1,013,277,292.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,741,000.00
210104	Урамшуулал	-	109,700,549.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	12,374,922.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	203,107,840.43
210201	Тэтгэврийн даатгал	-	168,993,508.86
210202	Тэтгэмжийн даатгал	-	8,602,308.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,302,761.40
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,648,129.78
210205	Эрүүл мэндийн даатгал	-	16,561,132.36
2104	Хангамж, бараа материалын зардал	-	370,290,305.00
210401	Бичиг хэрэг	-	56,111,320.00
210402	Тээвэр, шатахуун	-	45,092,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,258,880.00
210404	Ном, хэвлэл	-	210,419,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	336,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	55,071,365.00
2105	Нормативт зардал	-	198,721,778.89
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	23,912,783.16
210502	Хоол, хүнс	-	173,839,395.73
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	969,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	579,147,859.56
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	402,052,372.56
210602	Тавилга	-	1,188,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,950,000.00
210604	Урсгал засвар	-	172,957,487.00
2107	Томилолт, зочны зардал	-	291,069,734.00
210702	Дотоод албан томилолт	-	291,069,734.00

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,233,978,874.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,233,978,874.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,845,299,014.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,388,214,083.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,457,084,931.87
212	ТАТААС	-	1,064,577,362.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	1,064,577,362.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	1,064,577,362.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,288,362,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,288,362,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	25,572,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,262,790,500.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	1,603,190,330.62
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(1,603,190,330.62)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(1,603,190,330.62)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Хүний хөгжил”-ийн зорилгод “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ” гэж заасан байна.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, шинжлэх ухааны салбарын зөв, оновчтой бодлогыг тодорхойлж, бодитой үр нөлөө үзүүлэх олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн онцлох дараах ажлууд байна. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарлаж, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн;
- Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөр батлагдан, 2025-2026 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд хэрэгжиж эхэлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолоор 1 дэх хэсэгт шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг салбарын хамтын хэлэлцээр, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан төсөвтөө багтаан нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн;
- “Багийн бага сургууль” санаачилгын хүрээнд НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран ХААН банк, Номин холдинг групп зэрэг хувийн хэвшилтэй хамтран 5 байршилд багийн бага сургуульд байгуулах ажлыг эхлүүлсэн;
- 2025-2026 оны хичээлийн жилээс төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн III, IV ангийн сурагчид англи хэлийг нэмэлт хөтөлбөрөөр судалж эхэлсэн;
- Засгийн газрын 2025 оны 130 дугаар тогтоолоор Технологийн дэвшлийг ашиглан зайн сургалтаар дэлхийн түвшний боловсрол олгох зорилтын хүрээнд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий төрийн өмчийн “Ерөнхий боловсролын цахим сургууль” байгуулагдсан;
- Үндэстний цөөнхийн болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн “Хос хэлний боловсрол, сургалт зохион байгуулахад баримтлах чиглэл” батлагдсан;
- Мэргэжлийн болон техникийн боловсролд ажиллангаа суралцах нөхцөлийг бүрдүүлэх хосмог сургалтыг 60 гаруй аж ахуй нэгжтэй хамтран эхлүүлсэн;

- ЮНЕСКО-гийн “Суралцагч хотуудын сүлжээ”-нд анх удаа Монгол Улс нэгдсэн.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч зарим агентлагийн орон тооны дээд хязгаарыг 91 байхаар шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлагдаж, 2025 оноос даган мөрдөж байна;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 225 дугаар тогтоолоор Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 226 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2025 оны 4 дугаар сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг “боловсролыг дэмжих жил” болгон зарласан.

- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/405 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мэргэжлийн багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, ерөнхий эрдмийн багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, ерөнхий эрдмийн сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн дадлага, сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, багшийн хөгжил хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/37 дугаар тушаалаар Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/613 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам хүчингүй болсон;
- Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/87 дугаар тушаалаар Сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам батлагдсан;
- Боловсролын сайд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/136, А/80, А/69 дугаар тушаалаар Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлагдсан;
- Боловсролын сайд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/253, А/123 дугаар тушаал Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журам батлагдсан;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, хууль зүй, дотоод хэргийн сайд, гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаар тушаалаар Цахим

орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас Урьдчилан сэргийлэх, хамгаалах журам батлагдсан.

Дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн 3 байгууллагад төлөвлөгөөт, 11 байгууллагад төлөвлөгөөт бус дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийсэн байна. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар 15,232.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлснээс албан шаардлагын биелэлт 95.0 хувь, улсын байцаагчийн тогтоосон төлбөрийн актын биелэлт 34.0 хувьтай байна.

Аудитын гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийгдсэн аудитын дүнгээр залруулсан алдааны тоо 13.3 хувиар, санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчлийн тоо 13.5 хувиар өссөн бөгөөд энэ нь дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө сулыг харуулж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч хууль, тогтоомж, холбогдох журмын шинэчлэл, өөрчлөлттэй нийцүүлээгүй, салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй байна. Тухайлбал, дижитал сурах бичиг, цахим систем, олон улсын хөтөлбөрүүдийн бүртгэл, түрээсийн номын сангийн бүртгэл, сурах бичиг хэвлүүлэх, орлого авах, байгууллагуудад хуваарилж тараах, эргэн хяналт хэрэгжүүлэх зэрэгт бүртгэлээр баримтлах бодлого, зохицуулалтгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангаарх эцсийн үлдэгдэл,

“finperform.mof.gov.mn” цахим тайлан дах нэгтгэлийн дүнгээс нийт хөрөнгө 4,649.8 сая төгрөгөөр, нийт үр дүн 459.0 сая төгрөгөөр, нийт цэвэр хөрөнгө/өмч 7,419,153.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Энэ нь санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаа тул харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр албан шаардлага хүргүүлэв.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 696,837.4 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	589,085.2	346,013.3	(243,071.9)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	58.2	1,319.8	1,261.6
Авлага	347,734.8	352,178.5	4,443.7
Урьдчилгаа	174,330.7	233,357.0	59,026.3
Бараа материал	261,286.9	283,725.7	22,438.8
Нөөцийн хөрөнгө	-	49.3	49.3
Бусад эргэлтийн хөрөнгө	1,747,828.5	2,018,512.2	270,683.7
Үндсэн хөрөнгө	5,391,946.4	5,973,952.5	582,006.1
Нийт хөрөнгө	8,512,270.8	9,209,108.3	696,837.5
Өр төлбөр	161,236.9	123,193.0	(38,043.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,351,033.9	9,085,915.3	734,881.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,512,270.8	9,209,108.3	696,837.5

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн данс 346,013.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх оноос 243,071.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	3.5	16.7	13.2
Төгрөг	3.5	16.7	13.2
Банкинд байгаа бэлэн мөнгө	546,042.2	296,879.4	(249,162.8)
Төгрөг	536,864.4	293,833.7	(243,030.7)
Төрийн сангийн харилцах	460,057.8	212,888.6	(247,169.2)
Арилжааны банк дахь харилцах	76,638.3	80,945.1	4,306.8
Нэмэлт санхүүжилтийн харилцах	168.3	-	(168.3)
Гадаад валют	9,177.8	3,045.7	(6,132.1)
Монгол банк дахь харилцах	256.1	-	(256.1)
Арилжааны банк дахь харилцах	8,921.7	3,045.7	(5,876.0)
Замд яваа мөнгөн хөрөнгө	7.6	6.0	(1.6)
Хадгаламж	43,031.9	49,111.2	6,079.3
Дүн	589,085.2	346,013.3	(243,071.9)

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн 85.8 хувь буюу 296,879.4 сая төгрөг нь банкинд байгаа мөнгө, 14.2 хувь буюу 49,111.2 сая төгрөг нь хадгаламж, кассанд байгаа бэлэн мөнгө 16.7 сая төгрөг, харин 6.0 сая төгрөг нь замд яваа мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд тайлант онд Боловсролын ерөнхий газрын харьяа 706 сургууль, 1025 цэцэрлэг, 61 мэргэжлийн болон насан туршийн боловсролын байгууллагын зарцуулагдаагүй 186,132.6 сая төгрөг, барьцаа хөрөнгийн 13,903.5 сая төгрөг, түрээсийн сурах бичгийн эргэлтийн сангийн 7,404.1 сая төгрөг, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн 2,450.4 сая төгрөг, техник хяналтын дансны 2,236.6 сая төгрөг, ариун цэврийн байгууламжийн санхүүжилтийн дансны 761.4 сая төгрөг зэрэг нийт 212,888.6 сая төгрөг байршиж байна.

Арилжааны банканд 2025 оны жилийн эцэст төгрөгөөр болон валютаар байршиж байгаа мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.1 Арилжааны банкны үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Д/д	Байгууллагын нэр	Төгрөгийн дансны үлдэгдэл	Валютын дансны үлдэгдэл
1	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	25,234.5	132.1
2	Монгол Оросын хамтарсан сургууль	16,968.1	-
3	Монгол Улсын Их сургууль	10,343.7	1,331.2
4	Монгол Улсын Боловсролын Их Сургууль	10,828.1	424.4
5	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль	5,831.8	579.0
6	Соёл Урлагийн Их Сургууль	3,722.7	-
7	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	5,760.4	515.8
8	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	713.5	-
9	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	294.4	62.2
10	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв	31.3	-
11	ШУТИС-ын политехникийн коллеж	520.1	-
12	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	222.2	-
13	Бусад ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	713.5	-
14	Монгол Германы хамтарсан технологийн дээд сургууль	474.4	-
15	Боловсролын ерөнхий газар	-	-
16	Боловсролын зээлийн сан	-	1.0
Нийт		80,945.1	3,045.7

Тайлант онд арилжааны банкны төгрөгийн харилцах дансад 80,945.1 сая төгрөг, валютын харилцах дансад 3,045.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн 6.0 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгийн хадгаламжийн дансанд төрийн өмчийн 4 их сургуулийн нийт 49,111.2 сая төгрөг арилжааны банкинд байршиж байна. /МУБИС 20,362.8 сая

төгрөг, ШУТИС 17,273.6 сая төгрөг, МУИС 6,327.4 сая төгрөг, АШУҮИС 5,147.4 сая төгрөг/

Аудитын илрүүлэлт

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон байгуулсан гэрээний заалтыг дагаж мөрдөөгүй, гэрээ байгуулаагүй зардал гаргасан 11,162.5 сая төгрөг /ЕБС-ийн 93 зөрчил 4,867.3 сая төгрөг, БЕГ-ын ТШЗ-ийн 2 зөрчил 2,550.6 сая төгрөг, Их сургуулиудын 9 зөрчил 1,696.0 сая төгрөг, СӨББ-ын 70 зөрчил 1,039.1 сая төгрөг, МБСБ-ын 11 зөрчил 592.6 сая төгрөг, Боловсролын байгууллагуудын 3 зөрчил 93.5 сая төгрөг, НТББ-ын 1 зөрчил 23.4 сая төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдүүлэлт дутуу, хүчин төгөлдөр бус баримт, баримтын хөтлөлт, баталгаажуулалт хангалтгүй баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 14,602.2 сая төгрөг /Боловсролын зээлийн сан 3 зөрчил 10,480.0 сая төгрөг, ЕБС-ийн 74 зөрчил 1,864.1 сая төгрөг, Их сургуулиудын 13 зөрчил 1,176.8 сая төгрөг, СӨББ-ын 89 зөрчил 551.6 сая төгрөг, Их сургуулиудын 14 зөрчил 402.5 сая төгрөг, Боловсролын яам 4 зөрчил 57.2 сая төгрөг, Боловсролын газруудын 6 зөрчил 54.3 сая төгрөг, МБСБ-ын 4 зөрчил 15.7 сая төгрөг/;
- Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчиж Батлагдсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан, зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан, хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, хяналтгүй зарцуулсан 2,695.2 сая төгрөг /ЕБС-ийн 144 зөрчил 2,035.6 сая төгрөг, СӨББ-ын 157 зөрчил 462.4 сая төгрөг, Боловсролын газруудын 11 зөрчил 79.9 сая төгрөг, МБСБ-ын 13 зөрчил 63.9 сая төгрөг, Боловсролын зээлийн сан 2 зөрчил 41.4 сая төгрөг, Боловсролын яам 1 зөрчил 12.0 сая төгрөг, БЕГ-ын 1 зөрчил/;
- Үдийн хоол, үдийн цайны зардлын батлагдсан норм зөрчсөн, зардлын зориулалт өөрчилсөн, зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй, хүүхдийн бүртгэлийн тоо зөрүүтэй, хяналт тавьж ажиллаагүй 1,257.9 сая төгрөг /ЕБС-ийн 49 зөрчил 926.3 сая төгрөг, СӨББ-ын 69 зөрчил 313.5 сая төгрөг, МБСБ-ын 2 зөрчил 18.1 сая төгрөг/;
- Боловсролын болон Эрүүл мэндийн сайд нарын хамтран баталсан албан ёсны жагсаалтад байхгүй үзлэг, шинжилгээнд ажилтнуудыг хамруулсан, эмнэлгийн үйлчилгээ үзүүлээгүй байхад төлбөрийг шилжүүлсэн, холбогдох тайлан, актгүй зэрэг 60.5 сая төгрөг /ЕБС-ийн 10 зөрчил 52.2 сая төгрөг, СӨББ-ын 3 зөрчил 8.3 сая төгрөг, МБСБ-ын 1 зөрчил/;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү, дутуу тооцож олгосон, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан хаагчид хоол, унааны нөхөн олговор, цалин хөлс, балансын урамшуулал давхардуулж олгосон 6,858.8 сая төгрөг /ЕБС-ийн 523 зөрчил 3,494.4 сая төгрөг, СӨББ-ын 554 зөрчил 2,617.6 сая төгрөг, Боловсролын байгууллагуудын 33 зөрчил 412.3 сая төгрөг, МБСБ-ын 28 зөрчил 174.0 сая төгрөг, их сургуулийн 8 зөрчил 308.1 сая төгрөг, НТББ-ын 12 зөрчил 26.8 сая төгрөг, /;
- Орлогын төлөвлөгөө тасарсан, түрээсийн болон номын түрээсийн орлого, орон нутгаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй, орлого бүртгээгүй 1,109.2 сая төгрөг /ЕБС-ийн 71 зөрчил 893.6 сая төгрөг, Их сургуулийн 4 зөрчил 99.9 сая төгрөг, СӨББ-ын 14 зөрчил 90.6 сая төгрөг, МБСБ-ын 3 зөрчил 25.1 сая төгрөг, БЕГ ТТЗ-ийн 1 зөрчил, БЕГ-ын ТШЗ-ийн 2 зөрчил, Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа 1 зөрчил/.

3.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт данс 1,319.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх оноос 1,261.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	58.2	1,319.8	1,261.6
Дүн	58.2	1,319.8	1,261.6

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны 1,300.2 сая төгрөг буюу 98.5 хувийг Монгол Улсын Их сургуулийн эзэмшиж байгаа үнэт цаас, 19.6 сая төгрөг буюу 1.5 хувийг Боловсролын зээлийн сангийн жилийн 2 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн энгийн вексел эзэлж байна.

МУИС-ийн Ректорын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/617 дугаар тушаалаар баталсан “МУИС-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн удирдлагын журам” болон Дээд боловсролын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7 дахь заалтад заасан санхүүжилтийн эх үүсвэрт хүүгийн орлого багтах боломжтой тухай зохицуулалтын хүрээнд МУИС нь мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийн тодорхой хэсгийг үнэт цаас (бонд)-д хөрөнгө оруулж, хүүгийн орлого олох нөхцөлийг бүрдүүлсэн.

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкны хадгаламж, хадгаламжийн сертификат, Засгийн газрын болон компанийн өрийн хэрэгсэл зэрэг санхүүгийн хэрэгсэлд байршуулж болохоор зохицуулсны дагуу өрийн хэрэгсэл болох Бэрс бондыг 12 сарын хугацаатай, улирал тутам хүү төлөх давтамжтай, 19 хувийн хүүтэйгээр худалдан авсныг богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас ангиллаар бүртгэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан байна. Мөн Монгол Улсын Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор МУИС-ийн эзэмшлийн “Хөвсгөл усан зам” ХК-ийн 100.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй 23,606 ширхэг хувьцаа буюу 25 хувийн хувьцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдсан.

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор уг компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасах шийдвэр гарсан бөгөөд холбогдох журмын дагуу хувьцааг үнэт цаасны хоёрдогч зах зээлд борлуулан, хувьцааг хасах болон борлуулалтаас үүссэн олзыг санхүүгийн тайланд тусгасан байна.

Мөн Боловсролын зээлийн сангаас 2016–2017 онд арилжааны таван банкаар дамжуулан олгосон жилийн 2 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг энгийн векселиэр бүртгэсэн бөгөөд зээлийн эргэн төлөлт 38.7 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.3 Авлага

Авлага данс 352,178.5 сая төгрөг төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд өмнөх оноос 4,443.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1,299.5	2,316.4	1,016.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	13,109.8	21,183.2	8,073.4
Татаас, санхүүжилтийн авлага	754.4	9,097.7	8,343.3
Зээлийн хүүгийн авлага	0.1	0.1	-
Дансны авлага /ТӨҮГ/	13.3	24.3	11.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	110.7	116.6	5.9
Бусад авлага	63,070.1	17,876.5	(45,193.6)
Байгууллагаас авах авлага	60,791.9	16,316.1	(44,475.8)
Хувь хүмүүсээс авах авлага	2,278.2	1,560.4	(717.8)
Зээлийн авлага	269,376.9	301,563.9	32,187.0
Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	269,376.9	301,563.9	32,187.0
Дүн	347,734.8	352,178.5	4,443.7

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлага дансны үлдэгдэлд Боловсролын зээлийн сангийн сургалтын зээлийн сангийн авлага 301,563.9 сая төгрөг буюу 85.6 хувь, төлбөртэй үйлчилгээний авлага 21,183.2 төгрөг буюу 6.0 хувь, байгууллагаас авах авлага 16,316.1 сая төгрөг буюу 4.6 хувь, татаас, санхүүжилтийн авлага 9,097.7 сая төгрөг буюу 2.6 хувь, ажиллагчтай холбогдсон авлага 2,316.4 сая төгрөг буюу 0.7 хувь, бусад авлага 1,701.2 сая төгрөг буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Авлагын үлдэгдэл 4,443.7 сая төгрөгөөр өссөн нь сургалтын төрийн сангийн авлага, төлбөртэй үйлчилгээний авлага, татаас, санхүүжилтийн авлагын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай, эзэн холбогдогчгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй 10,206.9 сая төгрөг /БЕГ ТТЗ-ийн 1 зөрчил 7,274.3 сая төгрөг, Их сургуулийн 12 зөрчил 1,594.5 сая төгрөг, ЕБС-ийн 83 зөрчил 735.3 сая төгрөг, СӨББ-ын 96 зөрчил 417.7 сая төгрөг, бусад боловсролын байгууллагын 96.1 сая төгрөг, МБСБ-ын 8 зөрчил 78.8 сая төгрөг, Боловсролын газрууд 4 зөрчил 8.6 сая төгрөг, НТББ 1 зөрчил 1.6 сая төгрөг/

3.4.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс 233,357.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, өмнөх оноос 59,026.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	170,942.7	223,227.7	52,285.0
Урьдчилгаа тооцоо	3,388.0	10,129.4	6,741.4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	2,196.8	840.1	(1,356.7)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	367.7	9,228.0	8,860.3

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Цалингийн урьдчилгаа	95.4	26.5	(68.9)
Томилолтын урьдчилгаа	728.1	34.8	(693.3)
Дүн	174,330.7	233,357.0	59,026.3

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Боловсролын зээлийн сангийн 221,207.8 сая төгрөг буюу 94.8 хувь, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 9,228.0 сая төгрөг буюу 4.0 хувь, бусад байгууллагын 2,921.2 сая төгрөг буюу 1.2 хувийг тус тус эзэлж байна.

Боловсролын зээлийн сан нь журмын дагуу гэрээний үүргийн хэрэгжилтээр биелэлтийг тооцох нөхцөл заасан буцалтгүй тусламж, тэтгэлэгт 65,812.7 сая төгрөг, Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 108,459.4 сая төгрөг, Дэлхийн шилдэг их дээд сургуульд суралцагчдад олгосон сургалтын төлбөрийн зээлд 25,739.4 сая төгрөг, Засгийн газрын нэрэмжит тэтгэлэгт 19,617.7 сая төгрөг, гадаадад сурч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэлэгт 1,172.2 сая төгрөг, Дотоодын их дээд сургуульд суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээлд 406.4 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа дансанд бүртгэж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Ажиллагсадаас урьдчилгаа дутуу суутгасан, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй 646.1 сая төгрөг / ЕБС-ийн 6 зөрчил 553.4 сая төгрөг, ХААИС-ийн 1 зөрчил 55.2 сая төгрөг, СӨББ-ын 1 зөрчил 22.0 сая төгрөг, МБСБ-ын 2 зөрчил 15.5 сая төгрөг /.

3.4.5 Бараа материал

Бараа материалын данс 283,725.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, өмнөх оноос 22,438.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	45,006.0	50,289.7	5,283.7
Тусгай зориулалттай материал	39,526.1	43,853.7	4,327.6
Эм боох материал	5,479.9	6,436.0	956.1
Дуусаагүй үйлдвэрлэл	85.8	169.4	83.6
Бэлэн бүтээгдэхүүн	2,015.4	2,611.6	596.2
Хангамжийн материал	212,975.4	229,382.4	16,407.0
Бичиг хэргийн материал	5,979.9	6,714.7	734.8
Аж ахуйн материал	55,586.5	58,357.0	2,770.5
Сэлбэг хэрэгсэл	1,449.0	1,484.2	35.2
Түлш, шатах тослох материал	1,502.1	1,402.1	(100.0)
Барилгын засварын материал	3,802.9	3,517.7	(285.2)
Хүнсний материал	10,804.6	9,347.1	(1,457.5)
Бусад хангамжийн материал	133,850.6	148,559.5	14,708.9
Биологийн хөрөнгө	74.6	87.4	12.8
Мал амьтад	1,129.7	1,185.2	55.5
Дүн	261,286.9	283,725.7	22,438.8

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын дансны үлдэгдэлд нь ерөнхий боловсролын 709 сургуулийн үлдэгдэл 141,788.0 сая төгрөг буюу 50.0 хувь, сургуулийн өмнөх боловсролын 1020 байгууллагын 105,649.5 сая төгрөг буюу 37.2 хувь, мэргэжлийн боловсролын 32 байгууллагын 16,904.3 сая төгрөг буюу 6.0 хувь, аймаг, дээд боловсролын 6 байгууллагын 16,122.1 сая төгрөг буюу 5.7 хувь, нийслэлийн 32 боловсролын газар, хэлтсийн 1,326.3 сая төгрөг буюу 0.5 хувь, насан туршийн боловсролын 30 байгууллагын 438.9 сая төгрөг буюу 0.2 хувь, бусад 15 байгууллагын үлдэгдэл 1,496.6 сая төгрөг буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна. Мал амьтад дансанд Монгол Улсын их сургууль, Хөдөө аж ахуйн сургууль, сургуулийн өмнөх боловсролын 14, ерөнхий боловсролын 68 сургууль, политехникийн 12 коллежийн мал амьтад бүртгэлтэй байна.

Тайлант онд бараа материал худалдан авсан 373,908.6 сая төгрөг, хандиваар авсан 25,895.4 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 6,123.7 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр байгууллага хооронд шилжсэн 757.6 сая төгрөг, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 24,512.5 сая төгрөг, нийт 431,197.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаандаа зарцуулсан 385,351.5 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлсэн 4,537.8 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр байгууллага хооронд шилжсэн 1,401.3 сая төгрөг, данс хооронд шилжүүлэн бүртгэсэн 17,419.1 сая төгрөг, нийт 408,709.7 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа материалыг ангилал зөрүүлэн бүртгэсэн, бүртгэлд тусгаагүй орхигдуулсан, буруу тусгасан, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн 515.2 сая төгрөг /СӨББ-ын 24 зөрчил 271.4 сая төгрөг, ЕБС-ийн 19 зөрчил 155.3 сая төгрөг, Боловсролын газруудын 3 зөрчил 55.5 сая төгрөг, МБСБ-ын 4 зөрчил 31.6 сая төгрөг, НТББ-ын 1 зөрчил 1.4 сая төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, бүрдүүлэлт хангалтгүй, үр ашиггүй, шийдвэргүй, зориулалт бусаар зарцуулсан, хяналт хэрэгжүүлээгүй, бараа материалын тайлан гаргаагүй 2,598.5 сая төгрөг /СӨББ-ын 76 зөрчил 1,571.4 сая төгрөг, ЕБС-ийн 68 зөрчил 813.2 сая төгрөг, МБСБ-ын 5 зөрчил 213.7 сая төгрөг, НТББ 1 зөрчил 0.2 сая төгрөг, Боловсролын яам 1 зөрчил/;
- Бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, зах зээлийн бодит үнээс зөрүүтэй, тооллогоор дутсан, устгалын акт үйлдээгүй, 969.9 сая төгрөг /ЕБС-ийн 28 зөрчил 541.7 сая төгрөг, СӨББ-ын 33 зөрчил 424.8 сая төгрөг, НТББ-ын 1 зөрчил 2.8 сая төгрөг, МБСБ-ын 1 зөрчил 0.6 сая төгрөг/;
- Бараа материалыг хэрэглээнээс илүү бэлтгэсэн, тогтоосон орц норм баримтлаагүй, хугацаа хэтэрсэн, ашиглалтгүй, хориглосон хүнс худалдан авсан, эргэлт удааширсан 253.8 сая төгрөг /СӨББ-ын 21 зөрчил 103.5 сая төгрөг, ЕБС-ийн 18 зөрчил 83.9 сая төгрөг, Нийслэлийн боловсролын газар 1 зөрчил 51.6 сая төгрөг, МБСБ-ын 1 зөрчил 14.8 сая төгрөг/.

3.4.6 Нөөцийн бараа

Нөөцийн бараа данс 49.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Барааны нөөц	-	41.9	41.9
Тэжээлийн нөөц	-	2.0	2.0
Бусад нөөц	-	5.4	5.4
Дүн	-	49.3	49.3

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Энэ нь хөдөө аж ахуйн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нөөцийн бараа дансанд барааны нөөцийг 41.9 сая төгрөгөөр, бусад нөөцөөр 5.4 сая төгрөгөөр, тэжээлийн нөөцийг 2.0 сая төгрөгөөр тус тус тайлагнаснаас шалтгаалсан байна.

3.4.7 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс 2,018,512.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, өмнөх оноос 270,683.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	<i>/сая төгрөгөөр/</i> Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,747,828.5	2,018,512.2	270,683.7
Дүн	1,747,828.5	2,018,512.2	270,683.7

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажилд олгосон 122,517.0 сая төгрөг, Боловсролын салбарын байгууллагуудын хөрөнгө оруулалт, их засварын 1,592,658.2 сая төгрөг, мэргэжлийн боловсрол, сургалтын хөрөнгө оруулалт, их засварын дуусаагүй ажлууд 303,336.9 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Хөрөнгө оруулалтын нийт 72,223.1 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай, өмнөх оны зөрчил давтагдсан байна.

3.4.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн данс 5,973,952.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, өмнөх оноос 582,006.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	<i>/сая төгрөгөөр/</i> Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,316,960.6	4,893,021.6	576,061.0
Барилга, байгууламж, орон сууц	3,616,003.2	4,150,445.0	534,441.8
Авто-тээврийн хэрэгсэл	15,625.6	17,885.7	2,260.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	410,799.3	410,305.7	(493.6)
Тавилга, аж ахуйн эд хогшил	140,514.1	158,095.1	17,581.0
Зам, гүүрний байгууламж	5,874.6	8,941.7	3,067.1

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	481.5	470.2	(11.3)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	677.1	725.5	48.4
Бусад үндсэн хөрөнгө	51,478.4	64,271.3	12,792.9
Дуусаагүй барилга, байгууламж	33,206.1	39,108.1	5,902.0
Ном	42,300.9	42,773.3	472.4
Биет бус хөрөнгө	1,074,985.8	1,080,930.9	5,945.1
Программ хангамж	11,476.3	8,806.6	(2,669.7)
Бусад биет бус хөрөнгө	1,063,509.5	1,072,124.3	8,614.8
Дүн	5,391,946.4	5,973,952.5	582,006.1

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд 4,385,016.3 сая төгрөг буюу 73.4 хувь нь Боловсролын ерөнхий газрын харьяа байгууллагууд, 781,088.9 сая төгрөг буюу 13.1 хувь нь Их дээд сургуулийн хөрөнгийн менежментийн төв ТӨҮГ, 307,354.7 сая төгрөг буюу 5.1 хувь нь АШУҮИС, 125,465.1 сая төгрөг буюу 2.1 хувь нь ШУТИС, 114,023.5 сая төгрөг буюу 1.9 хувь нь МУИС, 62,585.9 сая төгрөг буюу 1.0 хувь нь МУБИС, 61,392.8 сая төгрөг буюу 1.0 хувь нь ХААИС, 137,025.3 сая төгрөг буюу 2.4 хувь нь бусад байгууллагын үлдэгдэл байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө худалдан авсан 75,439.2 сая төгрөг, хандиваар авсан 198,018.8 сая төгрөг, шилжүүлэн авсан 93,443.4 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр байгууллага хооронд шилжсэн 18,077.2 сая төгрөг, бусад байдлаар 550,133.9 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдлээр 13,520.4 сая төгрөг, нийт 948,632.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, бусдад худалдсан 841.5 сая төгрөг, акталсан 73,286.3 сая төгрөг, балансаас балансад шилжүүлсэн 26,301.4 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр байгууллага хооронд шилжүүлсэн 15,605.0 сая төгрөг, бусад 58,195.5 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдлоор 16,013.3 сая төгрөг, нийт 190,243.0 сая төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна. Тайлант оны элэгдлийн зардал 291,972.8 сая төгрөг, хасагдсан хөрөнгөд ногдох элэгдэл 112,653.0 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зөрүүтэй тоолж, баталгаажуулсан, хөрөнгө биетээр оршин байхгүй, тооллогын дүн бүртгэл дэх үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй, данс бүртгэлд тусгаагүй 11,061.8 сая төгрөг /ЕБС-ийн 51 зөрчил 8,107.7 сая төгрөг, СӨББ-ын 47 зөрчил 2,766.1 сая төгрөг, БЕГ-ын 2 зөрчил 63.7 сая төгрөг, Их сургуулиудын 4 зөрчил 358.4 сая төгрөг, Боловсролын газруудын 2 зөрчил 37.3 сая төгрөг, МБСБ-ын 2 зөрчил 22.9 сая төгрөг, НТББ-ын 3 зөрчил 20.1 сая төгрөг, бусад боловсролын байгууллагын 3 зөрчил/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглагдаж байгаа хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлээгүй 3,269.9 сая төгрөг /ЕБС-ийн 40 зөрчил 1,892.9 сая төгрөг, СӨББ-ын 64 зөрчил 836.0 сая төгрөг, бусад боловсролын байгууллагын 2 зөрчил 152.4 сая төгрөг, МБСБ-ын 6 зөрчил 144.9 сая төгрөг, Их сургуулийн 5 зөрчил 128.2 сая төгрөг, бусад 3 байгууллагын 3 зөрчил 115.5 сая төгрөг, НТББ-ын 1 зөрчил, БЕГ-ын 1 зөрчил/;
- Газрын гэрчилгээ, кадастрын зурагтай зөрсөн, барилга, байгууламжийн бүртгэл өөр байгууллагад бүртгэлтэй, бүртгэлд зөрүүтэй тайлагнасан, газар эзэмших хугацаа хэтэрсэн, санхүү бүртгэлд тусгаагүй, 6,853.3 сая төгрөг /ЕБС-ийн 15 зөрчил 4,158.4 сая төгрөг, СӨББ-ын 22 зөрчил 2,527.1 сая төгрөг, Нийслэлийн боловсролын газар 1 зөрчил 161.9 сая төгрөг, НТББ-ын 1 зөрчил 5.9 сая төгрөг, Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа 1 зөрчил, АШУИС-ийн 2 зөрчил/.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа буруу ангилсан, бараа материалын шинжтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, бөөн дүнгээр бүртгэсэн, тогтоол шийдвэргүй зардалд тусгасан, элэгдлийг зөрүүтэй тооцоолсон, харилцагч байгууллагаас хүлээн авахдаа хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж, баримтжуулаагүй, 3,148.9 сая төгрөг /СӨББ-ын 68 зөрчил 1,502.6 сая төгрөг, ЕБС-ийн 55 зөрчил 1,310.8 сая төгрөг, МБСБ-ын 3 зөрчил 333.6 сая төгрөг, НТББ-ын 2 зөрчил 1.9 сая төгрөг, БЕГ-ын 2 зөрчил, СУИС-ийн 1 зөрчил/;

3.4.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс 123,193.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, өмнөх оноос 38,043.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	161,199.6	123,160.7	(38,038.9)
Өглөг	98,403.2	59,354.7	(39,048.5)
Ажилчидтай холбогдсон өглөг	2,645.1	5,605.2	2,960.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,539.8	4,845.0	3,305.2
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	582.4	279.8	(302.6)
Бусад өглөг	93,635.9	48,624.8	(45,011.1)
Байгууллагад төлөх өглөг	92,934.7	46,151.3	(46,783.4)
Хувь хүмүүст төлөх өглөг	555.1	1,913.0	1,357.9
Татварын өглөг /ТӨҮГ/	85.0	90.1	5.1
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.2	419.4	419.2
Дансны өглөг /ТӨҮГ/	60.9	51.0	(9.9)
Урьдчилж орсон орлого	62,796.4	63,806.0	1,009.6
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	452.3	733.9	281.6
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	33,754.1	27,673.9	(6,080.2)
Бусад урьдчилж орсон орлого	28,590.0	35,398.2	6,808.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37.3	32.3	(5.0)
Урт хугацаат зээл	37.3	32.3	(5.0)
Төгрөг	37.3	32.3	(5.0)
Гадаад валют	37.3	32.3	(5.0)
Төслийн зээл	37.3	32.3	(5.0)
Дүн	161,236.9	123,193.0	(38,043.9)

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр дансны үлдэгдэлд Ерөнхий боловсролын 524 сургуулийн 21,459.7 сая төгрөг буюу 17.4 хувь, МУИС 20,647.8 сая төгрөг буюу 16.8 хувь, ШУТИС 20,220.3 сая төгрөг буюу 16.4 хувь, боловсролын салбарын хөрөнгө оруулалт, барьцаа дансны 14,357.6 сая төгрөг буюу 11.7 хувь, АШУҮИС 11,770.6 сая төгрөг буюу 9.6 хувь, МУБИС 10,971.3 сая төгрөг буюу 8.9 хувь, Сургуулийн өмнөх боловсролын 586 байгууллагын 6,242.7 сая төгрөг буюу 5.1 хувь, Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилтийн дансны өглөгийн үлдэгдэл 6,007.7 сая төгрөг буюу 4.9 хувь, СУИС 2,318.6 сая төгрөг буюу 1.9 хувь, ХААИС 1,924.6 сая төгрөг буюу 1.5 хувь, Боловсролын үнэлгээний төв 1,621.4 сая төгрөг буюу 1.3 хувь, Мэргэжлийн боловсролын 28 байгууллагын 1,285.6 сая төгрөг буюу 1.0 хувь, Ариун цэврийн байгууламж санхүүжилтийн дансны САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

өглөгийн үлдэгдэл 761.4 сая төгрөг буюу 0.6 хувь, бусад байгууллагын дансны үлдэгдэл 3,603.7 сая төгрөг буюу 2.9 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл байгууллагад төлөх өглөг 46,783.4 сая төгрөгөөр, төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого 6,080.2 сая төгрөгөөр, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг 302.6 сая төгрөгөөр, дансны өглөг 9.9 сая төгрөгөөр тус тус буурч, бусад урьдчилж орсон орлого 6,808.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 3,305.2 сая төгрөгөөр, ажилчидтай холбоотой өглөг 2,960.1 сая төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөг 1,357.9 сая төгрөгөөр, татвар, нийгмийн даатгалын өглөг 419.2 сая төгрөгөөр, засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв 281.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 32.3 сая төгрөг нь ШУТИС-ийн урт хугацаат зээлийн ангилалд өглөгөөр тусгагдсан бөгөөд Төрийн өмчийн хорооны 2011 оны 61 тоот тогтоолын дагуу “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-аас балансас балансад шилжүүлэн бүртгэж авсан Халаалтын цогц төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр бөгөөд 2032 онд төлөгдөж дуусна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс өглөг үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, илүү, дутуу тайлагнасан, бүртгэлд тусгаагүй, өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 3,501.1 сая төгрөг /ЕБС-ийн 73 зөрчил 2,756.5 сая төгрөг, СӨББ-ын 64 зөрчил 299.8 сая төгрөг, Их сургуулийн 5 зөрчил 244.2 сая төгрөг, МБСБ-ын 5 зөрчил 172.8 сая төгрөг, БЕГ-ын 1 зөрчил 272.0 сая төгрөг, Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв ТӨАТҮГ-ын 1 зөрчил 29.1 сая төгрөг, Боловсролын газруудын 3 зөрчил 2.6 сая төгрөг, Боловсролын яамны 1 зөрчил 0.5 сая төгрөг/.

3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,085,915.3 сая төгрөг болж, өмнөх оноос 734,881.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

Дансны нэр, төрөл	/ сая төгрөгөөр/		
	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	8,351,033.9	9,085,915.3	734,881.4
Засгийн газрын оруулсан капитал	1,102,747.2	1,267,381.8	164,634.6
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	272,490.4	437,951.1	165,460.7
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	830,256.8	829,430.8	(826.0)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	765,568.6	784,691.1	19,122.5
Хуримтлагдсан үр дүн	5,309,531.6	5,856,129.2	546,597.6
Өмнөх үеийн үр дүн	4,377,192.7	5,121,812.7	744,620.0
Тайлант үеийн үр дүн	932,339.0	734,316.5	(198,022.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,173,186.5	1,177,713.2	4,526.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,351,033.9	9,085,915.3	734,881.4

Эх сурвалж: БС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант хугацааны үр дүн нь Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өсөхөд голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 6,217,046.4 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,241,711.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,334.8 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөс (30,000.0) сая төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж Улсын Их хурал, Үндэсний аудитын газар, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудад 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 1а/95 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас 1,951,480.1 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийт зардлыг 4,265,566.3 сая төгрөгөөр баталсан байна.

Тодотголоор 2,067.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 4,263,499.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Улсын төсвөөс 4,253,360.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,477.3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 57.5 сая төгрөг, нийт 4,259,894.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас 3,919,420.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын биелэлт 92.0 хувьтай байна.

Боловсролын зээлийн сангийн зээлийн эргэн төлөлтөөс 30,000.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 17,921.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөснөөс 12,078.1 сая төгрөг буюу 40.3 хувиар тасарсан байна.

Хүснэгт 12. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт

/сая төгрөгөөр/					
Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	6,477.3	7,255.7	(778.4)	112.0
2	Туслах үйл ажиллагааны орлого	57.5	118.5	(61.0)	206.1
Дүн		6,534.8	7,374.2	(839.3)	112.8
3	Улсын төсвөөс санхүүжих	4,253,360.0	3,912,046.1	341,313.9	92.0
Нийт дүн		4,259,894.8	3,919,420.3	340,474.5	92.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,918,347.1 сая төгрөг буюу 91.9 хувьтай байна. Энэ нь урсгал зардлыг 240,737.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 104,756.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 13. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/
				Зөрүү
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1,112,709.9	1,053,589.8	59,120.1
2	71802 Ерөнхий боловсрол	2,257,582.7	2,134,215.4	123,367.3
3	71803 Дээд боловсрол	110,561.2	96,548.1	14,013.1
4	71804 Мэргэжлийн боловсрол	222,549.9	213,339.2	9,210.7
5	71805 Шинжлэх ухаан, технологи	35,724.5	5,937.9	29,786.6
6	71806 Насан туршийн боловсрол	12,872.9	12,189.4	683.5
7	71808 Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	495,025.4	388,904.6	106,120.8
8	71809 Боловсрол, ШУ-ны судалгаа шинжилгээ	16,472.5	13,622.7	2,849.8
Нийт		4,263,499.0	3,918,347.1	345,151.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд 20,489.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн ба үүний эх үүсвэрийг Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 3,386.2 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 9,327.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт туссан хөрөнгөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 4,839.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,937.5 сая төгрөгийг бүрдүүлж, урсгал зардалд 18,886.7 сая төгрөг зарцуулж, 1,603.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 379.5 сая төгрөгийг авлагат тооцон тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Судалгааны үр дүн

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас авсан судалгааны үр дүнг тайланд тусгалаа. Тухайлбал:

- Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу тайлант онд боловсролын салбарт орон тооны цомхотгол хийгдээгүй байна. Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 26-ны

өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр Боловсролын салбарын төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, дүнг танилцуулах, Боловсролын яамны зарим харьяа байгууллагын чиг үүрэгт хийсэн иж бүрэн шинжилгээний үр дүнд үндэслэн чиг үүргийн дахин хуваарилалт хийх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судалж танилцуулахыг Боловсролын сайдад даалгасан байна.

- “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэгт заасны дагуу төсвийн шууд захирагч нар тушаал гарган алба хаагчдын 1 өдрийн хоолны хөнгөлөлт 34.0 мянган төгрөг хүртэл, унааны хөнгөлөлт 8.0 төгрөг хүртэл тогтоож, харилцан адилгүй байдлаар олгож байна. Боловсролын салбарын орон нутагт ажиллаж байгаа багш, ажилчдын хоол, унааны хөнгөлөлт эдийн засгийн ангиллаар төсөвт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 1/554 дүгээр албан бичгийг үндэслэн өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас олгосон байна.
- Гадаад томилолт, гадаад зочин хүлээн авах арга хэмжээтэй холбоотой 122 арга хэмжээнд 2,445.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 9,850.8 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Боловсролын байгууллагын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 28 хуулийн этгээдтэй 160.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 154.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас төрд учирсан хохирлыг барагдуулах зардал 224.9 сая төгрөгөөс 221.3 сая төгрөгийг төсвөөс төлж, бусад эх үүсвэрээс 3.6 сая төгрөгийг төлсөн. Тайлант онд 175.7 сая төгрөгийн авлага үүсгэн, 24.4 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч, 21.2 сая төгрөгийг төлүүлэхээр дараагийн шатны байгууллагад хандсан байна.
- Боловсролын салбарын хэмжээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа Финландын Эдүтэн цахим системийг ашигласан лицензийн төлбөрт 4,063.4 сая төгрөг, Английн Пийрсон англи хэлний цогц хөтөлбөрийн лицензийн төлбөрт 7,683.1 сая төгрөг зэрэг программ хөгжүүлэлт, үйлчилгээний төлбөрт нийт 34,583.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд нийт 12 гадаад зээл, тусламжийн төслүүд хэрэгжиж байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоолын дагуу Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Нэгдсэн

төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц, орон тоог батлах тухай” 174 тоот тушаалаар баталсан. Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид 5 төсөл хэрэгжүүлэх нэгж нэгтгэгдсэн байна. Бусад гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилтийг ТЕЗ хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Хүснэгт 14. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Төсөл, хөтөлбөрийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн зорилго	Хэрэгжих хугацаа	Төслийг санхүүжүүлэгч улс, байгууллага, санхүүжилтийн хэмжээ, зарцуулалт
1	“Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” “Sustaining Access to and Quality of Education during Economic Difficulties Project”	Боловсролын яам	(i) Улаанбаатар хот ба зарим аймгийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалт буурч буйг зогсоох, (ii) эхлүүлээд буй сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийг дуусгахад дэмжлэг үзүүлэх, (iii) шинэ хөтөлбөрт тохирох дагалдах сургалтын болон заах материалын хангамжийг баталгаажуулах, (iv) шинэ хөтөлбөр, үнэлгээний шаардлагыг хангахын тулд багш, менежерүүдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, ба (v) боловсролын үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх	2020.11-2026.12	Азийн хөгжлийн банк 50.0 сая ам.доллар
2	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нэмэлт санхүүжилтийн төсөл	Боловсролын яам	-3 сургуулийн барилга өргөтгөн хүчин чадлыг 960 суудлаар нэмэгдүүлэх - 1 шинэ цэцэрлэг барьж, 5 цэцэрлэг өргөтгөн хүчин чадлыг 940 ороор нэмэгдүүлэх - Зорилтот 3 сургууль, 6 цэцэрлэгт шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх	2024.04.-2027.02	Азийн хөгжлийн банк 15.7 сая ам.доллар
3	Инженер технологийн дээд боловсрол төсөл “Higher Engineering Education Development” Project	Боловсролын яам, ШУТИС	Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчин, чанарыг шинэчлэн сайжруулах, нийт 1000 инженерийг Япон Улсад бэлтгэж эх орондоо ажиллуулах	2014.03-2027	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/ 7.5 тэрбум иен

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	“Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн хотхоны өргөтгөл” төсөл GMIT Campus Extension Project	Боловсролын яам	Сургуулийн номын сан, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах замаар GMIT кампус дахь боловсрол, судалгааны орчныг сайжруулах, одоо байгаа болон нэмэлт шинээр төлөвлөж буй лаборатори, сургалтын танхимуудыг иж бүрэн тоноглож, Их сургуулийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх	2020.12-2024.12	ХБНГУ-ын Сэргээн Босголтын Зээлийн Банк 7 сая евро
5	Атал Бихари Важпайн нэрэмжит мэдээллийн технологи, холбоо, аутсорсингийн төв байгуулах төсөл Atal Bihari Vajpayee Center for Excellence in Information Technology & Communicaiton and Outsourcing Center Project	Боловсролын яам	Олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийг байгуулж, улмаар мэдээллийн технологийн салбараар дамжуулан Монгол Улсын экспортыг дэмжих	2015.12–2026.12	Энэтхэг Улсын Засгийн газар /Эксим банк/ 20.0 сая ам.доллар
6	Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалтын төсөл	Боловсролын яам	Мэргэжлийн багшийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, “чадамжийн төв”-ийг хөгжүүлэх замаар барилга, цахилгаан, механикийн мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг сайжруулах	2024.01-2025.12	ХБНГУ Засгийн газар 2 сая евро
7	Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл EQUALтөсөл	Боловсролын яам	GPE олон улсын байгууллагаас олгодог Multiplier fund санхүүжилт нь одоо шинээр хэрэгжиж буй төслүүдэд нэмэлт санхүүжилт болж дэмжлэг үзүүлэх зорилготой	2022-2025.12	Глобал Партнершип фор эдүкэйшн 5 сая ам.доллар
8	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (GMIT) III	Боловсролын яам	Монгол-Германы ашигт малтмал, технологийн их сургуулийг олон улсын чиг хандлагад нийцсэн, чанарыг эрхэмлэсэн их сургуулийн хувьд эрдэс түүхий эдэд түшиглэсэн эдийн засгийн хөгжлийг хангахад чиглэсэн нарийн мэргэжлийн ба удирдах ажилтан бэлтгэх, мөн шинжлэх ухаан, технологийн мэдлэг, туршлага бий болгох	2024.01-2026.12	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ) 4 сая евро
9	ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсөл	Боловсролын яам, КОЙКА	А.Үндэсний хэмжээний сургуулийн хоолны үйлчилгээний үйл ажиллагааны удирдамжийг боловсруулж, загвар сургуулиудад дэмжлэг үзүүлэх замаар институтийн суурийг бий болгох Б.Сургуулийн хоолны үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх төв, түүний боловсролын хөтөлбөрөөр дамжуулан сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг удирдан чиглүүлэх	2022-2026	КОЙКА 8,000,000 ам.доллар

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	ХААИС-ийн сургалт, судалгаа, Аж үйлдвэрийн уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төсөл	Боловсролын яам, ХААИС, КОЙКА	А. Бүрэлдэхүүн хэсэг 1. Малын шинжлэх ухаан, биотехнологийн сургуулийн салбар-академийн уялдаа холбоотой тусгай сургалтын хөтөлбөр боловсруулах Б. Бүрэлдэхүүн хэсэг 2. Мал аж ахуйн технологийг дэмжих төв (цаашид “Төв” гэх) байгуулж, лабораторийн орчны суурийг тавих. С. Бүрэлдэхүүн хэсэг 3. Мал аж ахуйн өндөр түвшний мэргэжилтнүүдийг дэмжих, гарааны үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх	2022-2026	КОЙКА 5,000,000 ам.доллар
11	ЕБС-ийн сургуулиудад байгалийн ухаан, технологийн боловсрол олгох инновац хамтын ажиллагааг дэмжих төсөл	Боловсролын яам	ЕБС-ийн суралцагчдын оролцоо, өөртөө итгэх итгэл, хүйсийн тэгш байдлын мэдрэмж, шинжлэх ухааны үндэслэл, дижитал сургалтын үндсэн ур чадварыг сайжруулах Бүрэлдэхүүн 1. Багш нарын байгалийн ухаан, технологийн хичээлийг төлөвлөх, заах ур чадварыг нэмэгдүүлэх Бүрэлдэхүүн 2. Байгалийн ухаан, технологийн лабораторийг байгуулах Бүрэлдэхүүн 3. Сургуулийн байгалийн ухаан, технологийн боловсролын инновац, хамтын ажиллагааг дэмжих орчныг сайжруулах	2026-2029	КОЙКА 3,000,000 ам.доллар
12	Япон загварын инженер, технологийн боловсролоор дамжуулан инженер бэлтгэх орчныг сайжруулах төсөл - Коосен	Боловсролын яам	Инженерийн боловсролын бааз суурийг бэхжүүлэх зорилгоор 3 техникийн коллежид дадлагын төв барих, тоног төхөөрөмжөөр хангах. Бүрэлдэхүүн 1. Зөвлөх үйлчилгээ Бүрэлдэхүүн 2. Барилга угсралт Бүрэлдэхүүн 3. Тоног төхөөрөмж	2026-2031	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/ 1.869.0 сая иен

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Боловсролын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн орчныг сайжруулах, дотоод аудит, хяналт хэрэгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Тусгай хяналтын чиг үүргийн газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 02/1804 болон 2026 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 1а/1858 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудит хийж, баталгаажуулсан 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,085,777.5 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 40,857.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/69 дүгээр тушаалаар төсвийн шууд захирагч нарт санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах чиглэл хүргэгдсэн бөгөөд тушаалын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар жил бүр үнэлгээ хийдэг байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд харьяа байгууллагуудад дараах үндсэн чиглэлүүдээр хэрэгжиж байна.

Салбарын онцлогоос шалтгаалан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны үндсэн зардлыг (багш нарын цалин, хүүхдийн хоол г.м) хасдаггүй боловч яамны аппарат, захиргаа, удирдах шатны байгууллагуудад дараах байдлаар хэмнэлт хийгдсэн байна.

1. Тээврийн хэрэгслийн ашиглалт, хязгаарлалт:

- Илүүдэл болон өндөр шатахуун зарцуулалттай автомашинуудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүлээлгэн өгч, шатахуун болон машины сэлбэг, засвар үйлчилгээний зардлыг хэмнэсэн.

2. Баяр ёслол, бэлэг дурсгал, хүлээн авалтын зардал:

- Тайлангийн хурал, семинарыг өндөр үнэтэй зочид буудал, амралтын газруудад хийхийг хориглож, төрийн байгууллагуудын өөрсдийн хурлын танхимд эсвэл цахимаар зохион байгуулсан.

3. Цаасан суурьт хэрэглээ ба цахимжилт:

- Бичиг хэрэг, хэвлэлийн зардлыг бууруулахын тулд албан хэрэг хөтлөлтийг “ERP” систем болон “Eduten”, “E-Mongolia” зэрэг цахим системүүд рүү шилжсэнээр цаас, хор, шуудангийн зардлыг хэмнэсэн.

4. Орон тоо ба чиг үүргийн давхардал:

- Боловсролын яамны харьяа зарим давхардсан чиг үүрэгтэй төв, газруудын бүтцийг нийлүүлж, удирдах албан тушаалтны тоог багасгаж оновчтой болгох арга хэмжээ авсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудалтай холбоотой нийт 5 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Харьяа байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаагаас санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 284,363.3 сая төгрөгийн материаллаг хэмжээний зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мэдээллийн хяналтын тайланг тайлант онд салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас нэгтгэн дүгнэж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарт 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/6067 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлсэн байна.

Албан шаардлага

Илрүүлэлт 2: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт сул байгаагаас 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 321 байгууллагад нийт 198,193.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.3.6-д “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл”, 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.2.2.4-т “хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл”, 2.2.2.5-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 2.2.1.10-т “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 2.2.1.13-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт”, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд харьяа газруудын санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн зарим заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Албан шаардлага

Илрүүлэлт 3: Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нийцүүлэн Засгийн газар, Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран батлах зарим шийдвэр, захиргааны хэм хэмжээний актуудыг батлаагүйгээс хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх, харьяа байгууллагууд хэвийн үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн орчин бүрдэхгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж тус тус заасантай нийцэхгүй, Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх, багц цаг тооцох журмыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална”, 12 дугаар зүйлийн 12.4-т “Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, багш мэргэжлийн сонгон бүлэг зохион байгуулах журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 26 дугаар зүйлийн 26.1.1-д “Хөдөлмөрийн тухай хуулийн 106.3-т заасны дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын жишиг норм, нормативыг батлах”, 26.1.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежер, арга зүйч, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг батлах”, 26.1.11-д “зайн болон цахим сургалт зохион байгуулах, эзэмшсэн боловсролыг үнэлэх, дүйцүүлэх журам батлах”, 26.1.20-д “боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлах”, 39 дүгээр зүйлийн 39.1-д “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”, 39.2-т “Энэ хуулийн 39.1-д заасан орчны норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална”, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг тооцох, дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 9 дүгээр зүйлийн 9.13-т “Энэ хуулийн 9.12-т заасан чадамжийн төв, дадлагын баазад тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 9.16-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотуур байртай байж болно. Дотуур байранд

тавих шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно”, 11 дүгээр зүйлийн 11.2-т “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавих шаардлага, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 12 дугаар зүйлийн 12.5-д “Энэ хуулийн 12.4-т заасан зээл олгох журмыг Засгийн газар батална”, 23 дугаар зүйлийн 23.1.1-д “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох”, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт суралцах суралцагчийн тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 22 дугаар зүйлийн 22.7-д “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн заалтуудыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актуудыг батлаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Өмнөх аудитын шийдвэртэй холбоотой

Илрүүлэлт 4: Өмнөх аудитаар өгсөн “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай бүртгэгдсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд нэгтгэгдэн тайлагнаж байна. Гэвч санхүүгийн тайлангаа УСНББОУС-ын дагуу бэлтгэн толилуулж байгаа нь байгууллагын эрх зүйн статус болон санхүүгийн тайлагналын ангилал хооронд нийцэлгүй байдал үүсгэж байна” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын

байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Засгийн газрын тогтоолоор Боловсролын яамны стратеги, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орж хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар болж өөрчлөгдсөн тул өмнөх аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Төсөл хэрэгжиж дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг хийж цахим системээр тайлагнаагүй;
- Боловсролын салбарын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг хэлэлцэж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах үйл ажиллагаа хангалтгүй;
- Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд хяналт-шалгалт хийгээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч хууль, тогтоомж, холбогдох журмын шинэчлэл, өөрчлөлттэй нийцүүлээгүй, салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй байна. Тухайлбал, дижитал сурах бичиг, цахим систем, олон улсын хөтөлбөрүүдийн бүртгэл, түрээсийн номын сангийн бүртгэл, сурах бичиг хэвлүүлэх, орлого авах, байгууллагуудад хуваарилж тараах, эргэн хяналт хэрэгжүүлэх, зэрэгт бүртгэлээр баримтлах бодлого, зохицуулалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох нарийвчилсан зохицуулалтыг тусгаж, дотоод нөөц бололцоогоо ашиглан шинэчлэх.

Илрүүлэлт 2: Засгийн газрын 2025 оны Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 52 дугаар тогтоолоор Боловсролын ерөнхий газрын орон тоог 91 байхаар тогтоосон боловч 2021 оны Засгийн газрын 403 дугаар тогтоолыг баримталж, 171 орон тоогоор төлөвлөж, гүйцэтгэлээр 123 орон тоотой ажилласан нь Боловсролын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг тайлант онд шинэчлэн батлаагүйтэй холбоотой байна. Үүний улмаас чиг үүргийн давхардал, ажлын ачааллын тэнцвэргүй хуваарилалт бий болж, удирдлагын шийдвэр гаргалтад тодорхойгүй байдал үүсэх, хүний нөөцийн төлөвлөлтийн бодит байдал алдагдах эрсдэл үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д

“хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”; 17.1.4-т “төрийн байгууллагын орон тоо, цалин хөлсний төлөвлөлт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлаагүйтэй холбоотой чиг үүргийн давхардал, ажлын ачааллын тэнцвэргүй хуваарилалт, тодорхойгүй байдал, хүний нөөцийн төлөвлөлт алдагдах зэрэг эрсдэл үүсгэхгүй байх.

Илрүүлэлт 3: Боловсролын байгууллагын урамшуулал, нэмэгдэл, хөлсний зохицуулалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн давхардал, уялдаа холбоогүй байдал нь бодлого, санхүүгийн хэрэгжилтэд зөрчил, эрсдэл үүсгэсэн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн төсөв гүйцэтгэлийг үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор Засгийн газрын 2024 оны 25, 39 дүгээр тогтоолоор байгууллагын болон багшийн үнэлгээний урамшууллыг зохицуулсан боловч Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, 2022 оны 252 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн багш, туслах багш, ажилтнуудад улирлын үр дүнгийн урамшуулал олгох заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нь урамшууллыг давхардуулах, цалин хөлс зөрүүтэй олгогдох, төсвийн үр ашиггүй зарцуулалт бий болох зэрэг эрсдэл үүссэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Боловсролын байгууллагын урамшуулал, нэмэгдэл, хөлсний зохицуулалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн давхардал, уялдаа холбоогүй байдлаас үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн хууль, тогтоомжийн хэрэгжилт, харьяа байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, стандарт мөрдөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, захиргааны хэм хэмжээний актуудыг батлаагүй зэрэг үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын зарим шаардлагад бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.3 Түүвэрт хамрагдсан байгууллагуудын аудитаар:

Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тус төв нь Их сургуулиудын ашиглалтын өмнөх захиргааны даргын 2014 оны А/20 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч 2014 оноос хойш өөрчлөлт ороогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох нарийвчилсан зохицуулалтыг тусгаж, дотоод нөөц бололцоогоо ашиглан шинэчлэх.

Илрүүлэлт 2: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 12 мэдээг хугацаа хоцроож, 2 мэдээг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа политехник коллеж

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тус политехникийн коллеж нь Боловсролын ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу магадлан итгэмжлэгдээгүй байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.8-д “хуульд өөрөөр заагаагүй бол мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага батлах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Боловсролын ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу магадлан итгэмжлэл хийлгэх.

Илрүүлэлт 2: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 162 мэдээллээс 4 мэдээллийн хугацааг хоцроон байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.5-д ... аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх.

Монгол Улсын Их сургуулийн харьяа Эдийн засгийн хүрээлэн

Илрүүлэлт 1: Эдийн засгийн хүрээлэнгийн албан хаагчид нь МУИС-д үндсэн орон тоонд ажилладаг ч тус хүрээлэнгийн ажлыг хавсран гүйцэтгэж нэмэгдэл хөлс авч байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлд “Хэд хэдэн ажил үүрэг зэрэг гүйцэтгэх 56.1-д Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2-т “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно”, 57 дугаар зүйл. “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулах 57.1-д “Ажилтан үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн ажил олгогчдоо мэдэгдэх үүрэгтэй”, 57.2-т “Дараах тохиолдолд ажилтан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа үндсэн ажил олгогчоос зөвшөөрөл авна: 57.2.1-д ажилтан үндсэн ажил олгогчтой энэ хуулийн 65 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан; 57.2.2-т үндсэн ажил олгогчтой ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл зах зээлд өрсөлддөг аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах бол” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, тогтоомжид нийцүүлэн албан хаагчдын цалин, нэмэгдлийг тогтоох

СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн

Илрүүлэлт 1: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулвал зохих 146 мэдээллээс 2 мэдээг хугацаа хоцроож, 10 мэдээг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

бүрэн байх”, 4.1.3.”тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх.

МУИС-ийн харьяа Монгол судлалын хүрээлэн

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Монгол судлалын хүрээлэнгийн захирал болон нягтлан бодогч нь МУИС-д үндсэн орон тоонд ажилладаг ч тус хүрээлэнгийн ажлыг хавсран гүйцэтгэж нэмэгдэл хөлс авч байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйл.”Хэд хэдэн ажил үүрэг зэрэг гүйцэтгэх 56.1. Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2-т “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно”, 57 дугаар зүйл. “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулах 57.1.”Ажилтан үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн ажил олгогчдоо мэдэгдэх үүрэгтэй”, 57.2-т “Дараах тохиолдолд ажилтан зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа үндсэн ажил олгогчоос зөвшөөрөл авна: 57.2.1.ажилтан үндсэн ажил олгогчтой энэ хуулийн 65 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан; 57.2.2.үндсэн ажил олгогчтой ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл зах зээлд өрсөлддөг аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах бол” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, тогтоомжид нийцүүлэн тушаал, шийдвэрийг гаргах.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тус зөвлөл нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албаны захирлын 2019 оны 189 дүгээр тушаалаар баталж, 2021 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Гэвч тус бодлогын баримт бичигт өнөөг хүртэл өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл– Хөтөлбөр, зориулалт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, Дараа жилийн төсвийн төсөл гэсэн 3 төрлийн мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тайлант онд батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөж, батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 44.2-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна”, 44.3-т “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Тайлант онд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, 37 дугаар зүйлийн 37.1.2-т “хоёрдугаар үе шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авах”, 38.1-д “Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим

дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.2-т “Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ”, 14.4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны хууль, журмыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Тайлант онд гэрээг үнийн дүнгүйгээр гэрээ байгуулж, гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу 2.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3.1-д “гэрээний үнэ”, Иргэний тухай хууль 343 дугаар зүйлийн 343.1-д “Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ”, 344 дүгээр зүйлийн 344.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний үнийн дүн, төлбөрийн нөхцөл, хугацааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн тодорхой тусгаж байх зөвлөмж өгөв.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 4 албан шаардлага, 12 зөвлөмжийг 87.5 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 15. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	-	-	-	-	-
2	Албан шаардлага	4	128,404.9	4	128,404.9	100.0
3	Зөвлөмж	12	200,000.0	8	200,000.0	83.3
	Нийт дүн	16	328,404.9	12	328,404.9	87.5

Хэрэгжилт хангалтгүй 4 зөвлөмжид албан шаардлага хүргүүлэв. Тухайлбал,

- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай бүртгэгдсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн

захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд нэгтгэгдэн тайлагнаж байна. Гэвч санхүүгийн тайлангаа УСНББОУС-ын дагуу бэлтгэн толилуулж байгаа нь байгууллагын эрх зүйн статус болон санхүүгийн тайлагналын ангилал хооронд нийцэлгүй байдал үүсгэсэн;

2. Төсөл хэрэгжиж дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг хийж цахим системээр тайлагнаагүй;
3. Боловсролын салбарын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг хэлэлцэж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах үйл ажиллагаа хангалтгүй;
4. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд хяналт-шалгалт хийгээгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Боловсролын салбарын байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэст нэгтгэж, төвлөрүүлэн болох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар анхаарах.

Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалтын хэрэгжилтэд тавьсан хяналт, Боловсролын сайдын хөтөлбөр арга хэмжээний зардлыг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 130,303.6 сая төгрөгийн 1777 алдаа илэрснээс 130,158.8 сая төгрөгийн 1760 алдааг аудитын явцад залруулж, 144.8 сая төгрөгийн залруулаагүй 17 алдаанд 14 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 260,901.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,501.4 сая төгрөгийн зөрчилд 698 төлбөрийн акт тогтоож, 210,548.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 964 албан шаардлага хүргүүлж, 47,782.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1774 зөвлөмж өгч, 855.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 43 албан шаардлага хүргүүлж, 213.0 сая төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 261,046.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний 1865 байгууллагаас 1144 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 713 байгууллагыг түүвэрт хамруулж, татан буугдсан 3, нэгтгэгдсэн 1, шинээр байгуулагдсан 4 байгууллага (Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын 3-р цэцэрлэг, Цэнгэл сумын 5-р цэцэрлэг, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 34-р цэцэрлэг, Ховд аймгийн Жаргалант сумын 17-р цэцэрлэг) аудитад хамрагдаагүй байна.

Санал дүгнэлт гаргасан 1144 байгууллагаас 1060 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, 80 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгч, 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль, Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын долоо дугаар сургууль, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль тус тус “Сөрөг” дүгнэлт, Ховд аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль “Татгалзсан” дүгнэлт авсан байна.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудит

5.2.1 Аудитаар илэрсэн зөрчил

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын үр дүнд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, цалин урамшуулалтай холбоотой, хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай, он дамжсан, хэрэгжилт хангалтгүй, хөрөнгийн эх үүсвэргүй төсөл, арга хэмжээ, эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын ашиглаж буй барилга байгууламжийн газар буюу эзэмших эрхийн гэрчилгээ болон барилга байгууламжийн эзэмшил, бүртгэл, ажиллагсадтай холбоотой авлага, өглөг өссөн, Засгийн газраас буцалтгүй тусламжаар бий болсон хөрөнгийн бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой нийт 108,424.3 сая төгрөгийн 8 зөрчил илэрсэнд 8,504.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч, зөрчлийг

арилган, давтан гаргахгүй байх талаар 99,920.3 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 152,622.0 сая төгрөгийн материаллаг хэмжээний залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн. Нэгтгэгдсэн байгууллагуудаас Сөрөг дүгнэлт-3, Татгалзсан дүгнэлт-1, Хязгаарлалттай дүгнэлт-80 байгууллага авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Боловсролын сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” А/277 дугаар тушаалаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан байгууллагын нягтлан бодогч нарт үр бүтээл гаргасан эсэхээс үл хамаарч, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө 1 сар хүртэлх үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг тооцож олгосон нь улирал бүр олгодог үр дүнгийн урамшуулалтай давхардах, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээ хэтрэх зэрэг зөрчил давтагдан гарсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах,

гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг давхардуулан олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Боловсролын салбарын 2012-2025 оны хооронд хэрэгжиж дуусах 99,920.3 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай, он дамжсан, хэрэгжилт хангалтгүй, хөрөнгийн эх үүсвэргүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод

аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай байгаа шалтгааныг тодорхойлж, богино хугацаанд хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын ашиглаж буй барилга байгууламжийн газар буюу эзэмших эрхийн гэрчилгээ болон барилга байгууламжийн эзэмшил, бүртгэлтэй холбоотой асуудлууд шийдвэрлэгдэхгүй байгаа нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд буруу тайлагнагдаж, үйл ажиллагааны үр дүн үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

- Боловсролын ерөнхий газрын эзэмшиж, ашиглаж буй барилга байгууламжийн газар буюу эзэмших эрхийн гэрчилгээ нь санхүүгийн тайланд бүртгэлгүй, эзэмших эрх нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /хуучин нэрээр/-ны нэр дээр бүртгэлтэй;
- Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн үндсэн хөрөнгийн барилга, байгууламжийн дансанд 3,456.9 сая төгрөгийн 640 хүүхдийн суудалтай барилга, байгууламж бүртгэлтэй бөгөөд Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургууль тус барилгад үйл ажиллагаагаа явуулдаг;
Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн газар нь Нийслэлийн боловсролын газрын эзэмшилд байдаг;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 5,940.0 сая төгрөгийн өртөгтэй Оюутны дотуур байрны барилга Боловсролын яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй;
- Шинэ эхлэл сургуулийн барилга нь санхүүгийн тайланд бүртгэлтэй боловч газар нь Монгени сургуулийн эзэмшилд байдаг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн САГ-2026/3/НА-СТА-ТЕЗ

гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.-д “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4.-д “үнэн зөв байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын газар, барилга байгууламжийн эзэмшил, бүртгэлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Өмнөх оноос ажиллагсадтай холбоотой авлага 1,016.9 сая төгрөгөөр, өглөг 2,960.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт, удирдлага зохион байгуулалт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажиллагсадтай холбоотой авлага, өглөгийн өмнөх оноос нэмэгдсэн зөрчлийг арилган, үлдэгдлийг бууруулан ажиллах.

Илрүүлэлт 2: Боловсролын салбарт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас буцалтгүй тусламжаар 7 сургууль, 1 цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг 2019 оноос 3 үе шаттайгаар хэрэгжүүлж, 2020-2021 онд ашиглалтад орсон боловч

3 сургуулийн барилгын улсын комиссын акт эцэслэн баталгаажаагүй, эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэгдээгүй байна. Тухайлбал,

- Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн 1,083.3 сая төгрөгийн өртөгтэй барилга /2-р ээлж/ 148-р сургууль;
- Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн 1,718.1 сая төгрөгийн өртөгтэй барилга /3-р ээлж/ 154-р сургууль;
- Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд 920 хүүхдийн суудалтай сургуулийн 573.3 сая төгрөгийн өртөгтэй барилга /3-р ээлж/ 130-р сургууль.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.5-д “...Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас буцалтгүй тусламжаар баригдсан 3 сургуулийн барилгын улсын комиссын акт эцэслэн баталгаажуулж, эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлэх арга хэмжээ авах.

Илрүүлэлт 3: Боловсролын салбарын орон нутагт ажиллаж байгаа багш, ажилчдын хоол, унааны хөнгөлөлт эдийн засгийн ангиллаар төсөвт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 1/554 дүгээр албан бичгийг үндэслэн өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө эдийн засгийн ангиллаар бодитой төлөвлөж байх.

Илрүүлэлт 4: Сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудыг төрийн өмчийн барилга, байгууламжийн сул, зай талбайг судлан, дотоод нөөц бололцоогоо ашиглалгүйгээр 1,152.3 сая төгрөгөөр оффис түрээслэн, төсвийг үрэлгэн зарцуулж байна. Үүнд, Боловсролын зээлийн сан, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл, Боловсролын мэдээллийн технологийн төв.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “төсвийн ерөнхийлөн захирагч гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50,000 төгрөгөөр тогтоосугай” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудыг төрийн өмчийн барилга, байгууламжийн сул, зай талбайг судлан, дотоод нөөц бололцоогоо ашиглах, төсвийг үрэлгэн зарцуулахгүй байх.

5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагуудын аудитаар:

Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв

Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Төрийн аудитын байгууллагаас тус төвийн санхүүгийн тайланд аудит хийх хуваарьтай байхад 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд нэр бүхий хувийн аудитын компанитай гэрээ байгуулан 5.5 сая төгрөгийн төлбөр төлж, аудит хийлгэн дүгнэлт гаргуулсан, мөн 2025 онд хувийн аудитын компани руу 7.0 сая төгрөгийг гэрээ байгуулалгүй шилжүүлсэн боловч аудитын ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттай зохион байгуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн

44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагатай давхардуулж хувийн аудитын компаниар 12.5 сая төгрөгөөр аудит хийлгэж, төсвийг үрэлгэн зарцуулсан зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Төсөв захирагч нь 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацааны дагуу 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх үүрэгтэй ч санхүүгийн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 01/54 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт 52 хоногоор хугацаа хоцроон ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хугацаа хоцроон ирүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 1.7 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттай зохион байгуулах”, 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Их дээд сургуулиудын Хөрөнгийн менежментийн төвийн захирлын 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн Б/37 дугаар тушаалаар нэр бүхий ажилтныг “Хөрөнгийн менежмент, хөгжүүлэлтийн ахлах менежер”-ийн албан тушаалд туршилтын хугацаагаар томилж, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр чөлөөлсөн байна. Холбогдох албан тушаалтнуудаас асуулга авч тодруулахад тус

ажилтан нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу тус төвд ажиллаагүй, Боловсролын яаманд ажилласан бөгөөд ажлын төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлт ирүүлээгүй байхад 11.9 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттай зохион байгуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.3-т "ажилтны ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулсан байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу ажил гүйцэтгээгүй, ажлын төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлтийг ирүүлээгүй ажилтанд цалин хөлс олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Ажлаас чөлөөлөгдсөн 4 ажилтантай тооцоо хийж, гэрээг дүгнэлгүй 29.1 сая төгрөгийн цалингийн өглөг үүсгэсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.6-д "Ажил олгогч ажилтанд хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тухай шийдвэр, эрүүл мэндийн даатгалын дэвтэр, бусад баримт бичгийг хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон өдөр хүлээлгэн өгөх, цалин хөлс, олговор, тэтгэмжийг хууль, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу олгох үүрэгтэй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож олгож байх, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Төсвийг зохистой удирдаагүйгээс 6.0 сая төгрөгийн бусад авлага, 18.7 сая төгрөгийн татварын авлага тус тус үүсгэж, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба

Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Албан томилолтоор гадаадад ажилласан хавсралтад дурдсан албан хаагчдад 2.3 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 2.1-д “Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно”, 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1.унааны зардал; 2.2.2.байрны зардал; 2.2.3.хоолны зардал” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа политехник коллеж

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тус байгууллага нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй 278.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2

дугаар зүйлийн 2.2-т "захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Төсөв захирагч нь 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанаас хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг хугацаа хоцроон ирүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон холбогдох дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр СУИС-аас балансаас балансад 107.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 45.0 сая төгрөгийн барааг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-т "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно", ТӨБЗГ-ын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай"

271 дүгээр тогтоолын 5.1-д “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, 5.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон холбогдох дээд шатны байгууллагын шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгийг бүртгэж байх.

Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тус байгууллага нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу 9 иргэнд ажлын хөлсийг тооцож олгохдоо 12.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: 32.2.1. хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах, 32.2.2. орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйцэтгэх гэрээний дагуу ажилласан иргэдийн ажлын хөлсийг тооцож олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, тайлагнадаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Монгол Улсын Их сургуулийн харьяа Эдийн засгийн хүрээлэн

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тус байгууллага нь судалгааны ажлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр 75.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-д “Анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүй зардлыг бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тус оюутны байр нь нийт 216 оюутан байрлуулах хүчин чадалтай боловч 2025 оны эцсийн байдлаар 157 оюутантай буюу 72.7 хувийн дүүргэлттэй байгаа нь орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй байна.

Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/25 дугаар тушаалын 1 дэх хэсэг “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн хан-Уул дүүрэгт, шинээр баригдаж ашиглалтад орж байгаа Архангай аймгийн оюутны дотуур байр /300 ортой/-ны ашиглалтын өмнөх захиргааг байгуулсугай”, тус байгууллагын дүрмийн 5.3-т “Дарга нь захиргааны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” 5.4-т “Захиргааны хэвийн үйл ажиллагааг хангаж, санхүү төлбөрийн чадварыг дээшлүүлэх, нэр хүндийг өсгөх талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Оюутны дотуур байрны ашиглалтыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах

Илрүүлэлт 2: Тус захиргаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 5,940.0 сая төгрөгийн өртөгтэй оюутны дотуур байрны барилгын ашиглалтыг хариуцан, орлого олж, үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг. Гэвч тус барилга нь Боловсролын яамны санхүүгийн тайланд бүртгэлтэй, газрын гэрчилгээ нь тус захиргааны нэр дээр бүртгэлтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т үнэн зөв байх, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Оюутны дотуур байрны барилга Боловсролын яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа асуудлыг дээд шатны төсөв захирагчид хандаж шийдвэрлүүлэх

Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Боловсролын сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” А/277 дугаар тушаал болон Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирлын 2025 оны 7 дугаар сарын 03-

ны өдрийн А/33 дугаар тушаалаар нягтлан бодогчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1.6 сая төгрөгийн урамшуулал тооцож олгосон нь улирал бүр олгодог үр дүнгийн урамшуулалтай давхардсан, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг давхардуулан олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тус сургуулийн үндсэн хөрөнгийн барилга, байгууламжийн дансанд 3,456.9 сая төгрөгийн үнэ бүхий 640 хүүхдийн суудалтай Нийслэлийн ерөнхий боловсролын 133 дугаар сургуулийн үйл ажиллагаа явуулдаг барилга, байгууламж бүртгэлтэй бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2024.07.26-ны өдрийн 01/62 дугаар албан бичгээр шилжүүлэхээр хандсан боловч шийдвэрлэгдээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4.-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээг авч, шаардлагатай баримт бичгийг бэлтгэж, мэдээллээр хангах.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/277 дугаар тогтоолоор “урамшуулал олгох тухай” болон Шинэ эхлэл сургуулийн захирлын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Б/13 тоот тушаалаар нягтлан бодогчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1.6 сая төгрөгийн балансын урамшуулал тооцож олгосон нь улирал бүр олгодог үр дүнгийн урамшуулалтай давхардсан, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг давхардуулан олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/277 дугаар “Урамшуулал олгох тухай” тушаалаар нягтлан бодогчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1.6 сая төгрөгийн балансын урамшуулал тооцож олгосон нь улирал бүр олгодог үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг давхардуулан олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэлийг тооллогын комисс бүрэн баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлд үндсэн хөрөнгө, бараа материалын тоо ширхгийг тусгаагүй, илтгэх хуудсанд гүйцэтгэсэн огноог буруу тусгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.4 “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж тооллогыг чанартай гүйцэтгэх, тооллогын комиссын үүрэг хариуцлагыг сайжруулах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

№	Байгууллага нэгжийн нэр	Байгууллагын тоо	2025 оны санхүүгийн тайлангийн аудит			Дүгнэлт						Аудит хийсэн байгууллагын нэр
			ҮАГ	АНТАГ	АХЭ	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт гаргахаас татгалзсан	Түүвэрт	Аудитад хамрагдаагүй	
1	Архангай аймгийн Боловсролын газар	1		1		1						Архангай аймаг дахь Төрийн аудитын газар
2	Баян-Өлгий аймгийн Боловсролын газар	1		1		1						Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар
3	Баянхонгор аймгийн Боловсролын газар	1		1		1						Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
4	Булган аймгийн Боловсролын газар	1		1			1					Булган аймаг дахь Төрийн аудитын газар
5	Говь-Алтай аймгийн Боловсролын газар	1		1		1						Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар
6	Говьсүмбэр аймгийн Боловсролын газар	1			1	1						Миндүг Аудит ХХК
7	Дархан-Уул аймгийн Боловсролын газар	1		1		1						Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар
8	Дорнод аймгийн Боловсролын газар	1		1		1						Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
9	Дорноговь аймгийн Боловсролын газар	1		1						1		Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар
10	Дундговь аймгийн Боловсролын газар	1			1	1						Азуре Хүлүг Аудит ХХК
11	Завхан аймгийн Боловсролын газар	1		1		1						Завхан аймаг дахь Төрийн аудитын газар
12	Орхон аймгийн Боловсролын газар	1		1		1						Орхон аймаг дахь Төрийн аудитын газар

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	Өвөрхангай аймгийн Боловсролын газар	1			1	1						Өвөрхангай аймаг Дөлгөөн Хайрхан Уул аудит ХХК
14	Өмнөговь аймгийн Боловсролын газар	1		1		1						Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар
15	Сүхбаатар аймгийн Боловсролын газар	1			1	1						Шинжлэн магадлахуй ЭЗШ Аудит ХХК
16	Сэлэнгэ аймгийн Боловсролын газар	1		1		1						Сэлэнгэ аймаг дахь Төрийн Аудитын газар
17	Төв аймгийн Боловсролын газар	1		1		1						Төв аймаг дахь Төрийн Аудитын газар
18	Увс аймгийн Боловсролын газар	1		1		1						Увс аймаг дахь Төрийн аудитын газар
19	Ховд аймгийн Боловсролын газар	1		1			1					Ховд аймаг дахь Төрийн аудитын газар
20	Хөвсгөл аймгийн Боловсролын газар	1		1		1						Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
21	Хэнтий аймгийн Боловсролын газар	1			1	1						Ари файнэнс аудит ХХК
22	Нийслэлийн Боловсролын газар	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
23	Багануур дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
24	Нийслэлийн Багахангай дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
25	Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
26	Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
27	Налайх дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
28	Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
29	Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
30	Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
31	Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс	1		1		1						Нийслэл дэх төрийн аудитын газар
32	Монгол улсын их сургууль	1			1	1						Мэдээлэл Аудит ХХК

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

33	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	1			1	1					Мишээл Од Аудит ХХК
34	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг	1			1		1				Мишээл Од Аудит ХХК
35	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургууль	1		1		1					Дархан-Уул аймаг дахь Төрийн Аудитын газар
36	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль	1			1	1					Баби Тами Аудит ХХК
37	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль	1		1			1				Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар
38	Соёл урлагийн их сургууль	1			1	1					Анализ старт аудит ХХК
39	Хөдөө аж ахуйн их сургууль	1			1		1				Ашид баланс аудит ХХК
40	Монгол улсын Боловсролын их сургууль	1			1	1					Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК
41	Шинжлэх ухаан технологийн их сургууль	1			1	1					Эс Жи Эм Ди Аудит ХХК
42	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	1		1		1					Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар
43	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	1		1					1		Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар
44	Монгол Улсын Консерватори	1			1	1					Ажу мэргэн аудит ХХК
45	Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж	1		1		1					Завхан аймаг дахь Төрийн аудитын газар
46	Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	1			1	1					Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
47	Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль	1			1		1				Цэгц богд аудит ХХК
48	Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын Бэрх сургууль	1		1		1					Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар
49	Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	1			1	1					Уваа-уул аудит ХХК
50	Боловсролын үнэлгээний төв	1			1	1					Ихмонгол хөлөг аудит ХХК

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51	Боловсролын мэдээллийн технологийн төв	1			1	1						Ихмонгол хөлөг аудит ХХК
52	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	1			1	1						Ихмонгол хөлөг аудит ХХК
53	Цөмийн физикийн судалгааны төв	1	1							1		Үндэсний аудитын газар
54	Уул уурхайн хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
55	СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
56	Хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
57	Дулаан техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
58	Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
59	Ой модны сургалт судалгааны хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
60	Монгол улсын их сургуулийн харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
61	Монгол улсын их сургуулийн харьяа монгол судлалын хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
62	Монгол улсын их сургуулийн харьяа эдийн засгийн хүрээлэн	1	1							1		Үндэсний аудитын газар
63	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль	1	1							1		Үндэсний Аудитын газар
64	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль	1	1							1		Үндэсний Аудитын газар
65	Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	1	1							1		Үндэсний Аудитын газар
66	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	1	1							1		Үндэсний Аудитын газар
67	Сурах бичгийн түрээсийн тогтолцоо	1	1							1		Үндэсний Аудитын газар
68	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв ТӨАТҮГ	1	1							1		Үндэсний Аудитын газар
69	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Политехник коллеж	1	1							1		Үндэсний Аудитын газар

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

70	Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар	1	1							1		Үндэсний Аудитын газар
71	Боловсролын салбарын Хөтөлбөр арга хэмжээ	1	1							1		Үндэсний Аудитын газар
72	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	1	1							1		Үндэсний Аудитын газар
73	Боловсролын яам	1	1			1						Үндэсний аудитын газар
74	Боловсролын зээлийн сан	1	1				1					Үндэсний Аудитын газар
75	Боловсролын ерөнхий газар ТТЗ	1791	7	849	935	1015	73	3	1	691	8	Үндэсний аудитын газар
76	Боловсролын сайд ТЕЗ	1	1				1					Үндэсний аудитын газар
	Бүгд	1,866	30	881	955	1,060	81	3	1	713	8	

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/																
Аймаг, Нийслэл, байгууллагын нэр	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Математик тооцоололтой холбоотой		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэн-тэй холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
											Залруулсан		Залруулаа-гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Боловсролын ерөнхий газар ТТЗ	1,666	115,206.2	1,049	65,982.2	32	602.3	395	41,055.6	190	7,566.1	1,659	115,138.2	7	67.9	7	67.9
Боловсролын яам	4	181.5	1	32.2	-	-	3	149.3	-	-	4	181.5	-	-	-	-
Баян-Өлгий аймгийн Боловсролын газар	1	89.7	1	89.7	-	-	-	-	-	-	1	89.7	-	-	-	-
Булган аймгийн Боловсролын газар	2	18.5	-	-	-	-	2	18.5	-	-	2	18.5	-	-	-	-
Говь-Алтай аймгийн Боловсролын газар	2	25.0	-	-	-	-	-	-	2.0	25.0	2	25.0	-	-	-	-
Говьсүмбэр аймгийн Боловсролын газар	2	4.5	1	-	-	-	1	4.5	-	-	2	4.5	-	-	-	-
Дорнод аймгийн Боловсролын газар	1	71.8	1	71.8	-	-	-	-	-	-	1	71.8	-	-	-	-
Дорноговь аймгийн Боловсролын газар	1	3.0	1	3.0	-	-	-	-	-	-	1	3.0	-	-	-	-
Дундговь аймгийн Боловсролын газар	1	36.8	-	-	-	-	1	36.8	-	-	1	36.8	-	-	-	-
Өвөрхангай аймгийн Боловсролын газар	4	74.1	1	1.3	-	-	3	72.8	-	-	4	74.1	-	-	-	-
Өмнөговь аймгийн Боловсролын газар	2	1,435.8	1	1,402.1	-	-	-	-	1	33.7	1	1,402.1	1	33.7	1	33.7
Увс аймгийн Боловсролын газар	1	68.8		-	-	-	1	68.8	-	-	1	68.8	-	-	-	-
Ховд аймгийн Боловсролын газар	1	3.8	1	3.8	-	-	-	-	-	-	1	3.8	-	-	-	-
Хэнтий аймгийн Боловсролын газар	1	10.4	1	10.4	-	-	-	-	-	-	1	10.4	-	-	-	-
Нийслэлийн Боловсролын газар	2	26.5	2	26.5	-	-	-	-	-	-	2	26.5	-	-	-	-
Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс	1	7.2	1	7.2	-	-	-	-	-	-	1	7.2	-	-	-	-
Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс	1	0.7		-	-	-	1	0.7	-	-	1	0.7	-	-	-	-
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	3	59.0	1	44.1	-	-	2	14.9	-	-	3	59.0	-	-	-	-
Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	2	914.5	2	914.5	-	-	-	-	-	-	2	914.5	-	-	-	-
Боловсролын зээлийн сан	3	295.0	3	295.0	-	-	-	-	-	-	3	295.0	-	-	-	-
Боловсролын үнэлгээний төв	4	1,361.9	1	0.5	-	-	2	1,361.4	1	-	4	1,361.9	-	-	-	-
Боловсролын мэдээллийн технологийн төв	2	72.6	1	72.6	-	-	-	-	1	-	2	72.6	-	-	-	-
Монгол улсын их сургууль	2	1,519.5	-	-	-	-	2	1,519.5	-	-	2	1,519.5	-	-	-	-
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	13	761.4	8	511.8	-	-	5	249.6	-	-	8	739.3	5	22.2	5	22.2
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлэг	6	1,450.4	1	37.5	-	-	-	-	5.0	1,412.9	6	1,450.5	-	-	-	-
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургууль	1	8.0	-	-	-	-	1	8.0	-	-	1	8.0	-	-	-	-

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль	1	30.4	-	-	-	-	1	30.4	-	-	1	30.4	-	-	-	-
Соёл урлагийн их сургууль	16	705.3	14	700.2	-	-	2	5.1	-	-	12	684.2	4	21.1	4	21.1
Монгол улсын Боловсролын их сургууль	2	31.9	2	31.9	-	-	-	-	-	-	2	31.9	-	-	-	-
Шинжлэх ухаан технологийн их сургууль	3	182.1	1	137.0	-	-	1	28.6	1	16.5	3	182.1	-	-	-	-
Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ёс дүгээр сургууль	5	70.1	4	67.7	-	-	1	2.4	-	-	5	70.1	-	-	-	-
Монгол Улсын Консерватор	3	627.0	2	252.9	-	-	1	374.1	-	-	3	627.0	-	-	-	-
Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	2	462.5	2	462.5	-	-	-	-	-	-	2	462.5	-	-	-	-
Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	6	624.3	2	320.8	-	-	2	42.0	2	261.5	6	624.2	-	-	-	-
Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	3	3,711.4	3	3,711.4	-	-	-	-	-	-	3	3,711.4	-	-	-	-
Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль	1	0.5	-	-	-	-	-	-	1	0.5	1	0.5	-	-	-	-
Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	2	3.4	1	3.4	-	-	1	-	-	-	2	3.4	-	-	-	-
Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж	1	142.0	1	142.0	-	-	-	-	-	-	1	142.0	-	-	-	-
Эдийн засгийн хүрээлэн	1	2.8	1	2.8	-	-	-	-	-	-	1	2.8	-	-	-	-
Монгол судлалын хүрээлэн	1	3.4	1	3.4	-	-	-	-	-	-	1	3.4	-	-	-	-
Бүгд	1,777	130,303.6	1,112	75,342.3	32	602.3	428	45,042.8	204	9,316.2	1,760	130,158.8	17	144.8	14	144.8

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		/сая төгрөгөөр/ Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсролын зээлийн сан	8	10,614.7	-	-	6	10,585.9	2	28.8	-	-	-	-
2	Монгол Улсын Консерватори	2	0.3	1	0.3	-	-	1	-	-	-	-	-
3	Монгол германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	3	41.7	-	-	-	-	3	41.7	-	-	-	-
4	Боловсролын мэдээллийн технологийн төв	4	34.7	-	-	2	34.7	2	-	-	-	-	-
5	Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	4	15.7	1	9.4	-	-	3	6.3	-	-	-	-
6	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол - Японы эмнэлэг	8	1,112.0	-	-	2	469.2	5	446.7	1	196.1	-	-
7	Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль	6	142.1	-	-	3	109.6	3	32.5	-	-	-	-
8	Боловсролын үнэлгээний төв	2	8.6	1	0.7	1	7.9	-	-	-	-	-	-
9	Боловсролын яам	9	69.6	-	-	6	57.6	3	12.0	-	-	-	-
10	Соёл-Урлагийн их сургууль	6	55.9	-	-	2	35.6	4	20.3	-	-	-	-
11	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	15	1,673.7	1	5.2	5	1,129.1	9	539.4	-	-	-	-
12	Монгол Улсын Боловсролын их сургууль	3	12.7	-	-	2	8.8	1	3.9	-	-	-	-
13	Шинжлэх ухаан технологийн их сургууль	8	795.4	-	-	2	535.7	6	259.7	-	-	-	-
14	Монгол Улсын Их сургууль	7	578.1	2	1.2	2	193.0	3	383.9	-	-	-	-
15	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	14	1,094.3	2	9.7	3	513.0	6	167.7	3	403.9	-	-
16	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	1	2.3	1	2.3	-	-	-	-	-	-	-	-
17	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа политехник коллеж	2	278.2	-	-	2	278.2	-	-	-	-	-	-
18	Архангай аймгийн Боловсролын газар	3	11.9	1	4.4	2	7.5	-	-	-	-	-	-
19	Баян-Өлгий аймгийн Боловсролын газар	3	9.2	1	0.8	1	4.5	1	3.9	-	-	-	-
20	Баянхонгор аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
21	Булган аймгийн Боловсролын газар	5	119.9	3	3.2	1	1.2	1	115.5	-	-	-	-
22	Говь-Алтай аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
23	Говьсүмбэр аймгийн Боловсролын газар	2	1.9	1	0.5	-	-	1	1.4	-	-	-	-
24	Дархан-Уул аймгийн Боловсролын газар	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
25	Дорнод аймгийн Боловсролын газар	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
26	Дорноговь аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
27	Дундговь аймгийн Боловсролын газар	3	4.1	1	1.6	-	-	2	2.5	-	-	-	-
28	Завхан аймгийн Боловсролын газар	1	6.3	1	6.3	-	-	-	-	-	-	-	-
29	Орхон аймгийн Боловсролын газар	6	47.7	2	0.6	3	47.1	1	-	-	-	-	-

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

30	Өвөрхангай аймгийн Боловсролын газар	1	12.0	-	-	-	-	1	12.0	-	-	-	-
31	Өмнөговь аймгийн Боловсролын газар	1	2.4	-	-	1	2.4	-	-	-	-	-	-
32	Сүхбаатар аймгийн Боловсролын газар	2	0.1	-	-	-	-	2	0.1	-	-	-	-
33	Сэлэнгэ аймгийн Боловсролын газар	1	0.3	-	-	1	0.3	-	-	-	-	-	-
34	Төв аймгийн Боловсролын газар	3	7.9	1	0.1	1	1.6	1	6.2	-	-	-	-
35	Увс аймгийн Боловсролын газар	1	45.9	-	-	1	45.9	-	-	-	-	-	-
36	Ховд аймгийн Боловсролын газар	4	291.6	1	1.2	1	-	2	290.4	-	-	-	-
37	Хөвсгөл аймгийн Боловсролын газар	1	38.9	-	-	1	38.9	-	-	-	-	-	-
38	Хэнтий аймгийн Боловсролын газар	3	0.2	-	-	3	0.2	-	-	-	-	-	-
39	Нийслэлийн Боловсролын газар	5	307.5	1	11.2	-	-	4	296.3	-	-	-	-
40	Багануур дүүргийн Боловсролын хэлтэс	1	0.6	-	-	-	-	1	0.6	-	-	-	-
41	Нийслэлийн Багахангай дүүргийн Боловсролын хэлтэс	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
42	Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс	1	3.6	-	-	1	3.6	-	-	-	-	-	-
43	Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтэс	2	6.2	-	-	-	-	2	6.2	-	-	-	-
44	Налайх дүүргийн Боловсролын хэлтэс	3	1.9	1	0.3	1	-	1	1.6	-	-	-	-
45	Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтэс	2	32.3	-	-	1	25.6	1	6.7	-	-	-	-
46	Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс	1	12.5	-	-	1	12.5	-	-	-	-	-	-
47	Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэс	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
48	Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэс	1	3.8	-	-	-	-	1	3.8	-	-	-	-
49	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны сургууль	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
50	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургууль	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
51	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль	2	86.8	-	-	-	-	2	86.8	-	-	-	-
52	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	1	0.6	-	-	-	-	1	0.6	-	-	-	-
53	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль	10	412.9	3	4.3	1	12.1	6	396.5	-	-	-	-
54	Монгол Улсын Консерваторын харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж	9	57.6	4	35.8	4	21.8	1	-	-	-	-	-
55	Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын Бэрх сургууль	1	4.3	-	-	1	4.3	-	-	-	-	-	-
56	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн	4	22.1	1	0.2	1	3.4	2	18.5	-	-	-	-
57	Цөмийн физикийн судалгааны төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
58	Уул уурхайн хүрээлэн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
59	СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн	1	152.4	-	-	-	-	1	152.4	-	-	-	-
60	Хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
61	Дулаан техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
62	Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн	1	12.9	-	-	1	12.9	-	-	-	-	-	-
63	Ой модны сургалт судалгааны хүрээлэн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

64	Монгол улсын их сургуулийн харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
65	Монгол улсын их сургуулийн харьяа монгол судлалын хүрээлэн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
66	Монгол улсын их сургуулийн харьяа эдийн засгийн хүрээлэн	1	75.0	-	-	1	75.0	-	-	-	-	-	-
67	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль	2	1.6	-	-	1	1.6	1	-	-	-	-	-
68	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль	1	1.6	-	-	1	1.6	-	-	-	-	-	-
69	Нийслэлийн ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	2	3,458.5	-	-	1	1.6	1	3,456.9	-	-	-	-
70	Архангай аймгийн оюутны дотуур байрны ашиглалтын өмнөх захиргаа	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-
71	Сурах бичгийн түрээсийн тогтолцоо	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
72	Их дээд сургуулиудын хөрөнгийн менежментийн төв ТӨАТҮГ	6	80.0	1	12.5	5	67.5	-	-	-	-	-	-
73	Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
74	Боловсролын салбарын Хөтөлбөр арга хэмжээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
75	Боловсролын ерөнхий газар	3,269	130,612.2	666	1,389.6	884	96,277.2	1,678	32,476.8	39	255.6	2	213.0
	Дүн	3,473	152,477.1	698	1,501.4	960	110,628.5	1,770	39,278.6	43	855.6	2	213.0
76	Боловсролын сайд ТЕЗ	8	108,424.3	-	-	4	99,920.3	4	8,504.0	-	-	-	-
	Нийт дүн	3,481	260,901.4	698	1,501.4	964	210,548.8	1,774	47,782.6	43	855.6	2	213.0

6.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсролын зээлийн сан	7	-	-	-	-	-	7	-	-	-
2	Монгол Улсын Консерватор	1	-	-	-	1	-	-	-	-	-
3	Монгол германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Боловсролын мэдээллийн технологийн төв	1	-	-	-	-	-	1	-	-	-
5	Нийслэлийн ерөнхий боловсролын зуун арван зургаа дугаар сургууль	1	205.3	-	-	-	-	1	205.3	-	-
6	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол – Японы эмнэлэг	4	390.1	-	-	3	129.4	1	260.7	-	-
7	Нийслэлийн ерөнхий боловсролын хорин ес дүгээр сургууль	2	556.4	-	-	2	556.4	-	-	-	-
8	Боловсролын үнэлгээний төв	1	-	-	-	-	-	1	-	-	-
9	Боловсролын яам	4	1,001.7	-	-	1	19.4	2	65.9	1	916.4
10	Соёл-Урлагийн их сургууль	3	738.4	-	-	1	39.9	2	698.5	-	-
11	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	1	1,801.0	-	-	1	1,801.0	-	-	-	-
12	Монгол Улсын Боловсролын их сургууль	3	175.0	-	-	1	-	2	175.0	-	-
13	Шинжлэх ухаан технологийн их сургууль	1	1,411.2	-	-	1	1,411.2	-	-	-	-
14	Монгол Улсын Их сургууль	2	810.9	-	-	1	80.0	1	730.9	-	-
15	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	3	13,273.7	-	-	1	35.7	1	-	1	13,238.0
16	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл	1	-	-	-	-	-	1	-	-	-
17	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа политехник коллеж	2	-	-	-	-	-	2	-	-	-
18	Архангай аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
19	Баян-Өлгий аймгийн Боловсролын газар	1	414.8	-	-	-	-	1	414.8	-	-
20	Баянхонгор аймгийн Боловсролын газар	1	-	-	-	1	-	-	-	-	-
21	Булган аймгийн Боловсролын газар	1	-	-	-	-	-	1	-	-	-
22	Говь-Алтай аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
23	Говьсүмбэр аймгийн Боловсролын газар	1	2.6	-	-	1	2.6	-	-	-	-
24	Дархан-Уул аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
25	Дорнод аймгийн Боловсролын газар	1	329.9	-	-	1	329.9	-	-	-	-

Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

26	Дорноговь аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
27	Дундговь аймгийн Боловсролын газар	2	0.1	-	-	1	0.1	-	-	1	-
28	Завхан аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
29	Орхон аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
30	Өвөрхангай аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
31	Өмнөговь аймгийн Боловсролын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
